



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ХЯНАЛТ ТАВИХ ТОГТОЛЦОО БҮРДСЭН БОЛОВЧ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН НЭГДСЭН УДИРДЛАГА, БАЙГУУЛЛАГУУДЫН УЯЛДАА ХАНГАЛТГҮЙГЭЭС ХЯНАЛТ БҮРЭН, ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ӨВА-2026/36/ШТА-НА



Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал

Утас: 7032-3253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер П.Хорлоосүрсэн

Утас: 7032-3108 Цахим хаяг: KhorloosurenP@audit.gov.mn

Ахлах аудитор: Ө.Ринчинмядаг

Утас: 7032-3833 Цахим хаяг: RinchinmyadagU@audit.gov.mn

Аудитор: Р.Энхзул

Утас: 7032-3833 Цахим хаяг: EnkhzulR@audit.gov.mn

Аудитор: Д.Очирбат

Утас: 7032-3833 Цахим хаяг: OchirbatD@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг www.audit.mn хаягаас авна уу.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	4
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО БҮРДСЭН БОЛОВЧ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АЙМАГ, СУМДЫН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	7
1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд хяналт хэрэгжүүлэхэд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам хоорондын уялдаа холбоо хангагдсан, бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.	7
1.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймгаас хэрэгжүүлж буй ТАХ-нд хяналт тавьж буй байгууллагуудад нарийн мэргэжлийн хүний нөөцөөр хангагдсан боловч сумдад мэргэжлийн боловсон хүчин байхгүй, аймаг сумдын харилцан уялдаат байдал дутмаг байна.	9
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ТАВИХ ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ САЙЖИРСАН БОЛОВЧ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.....	13
2.1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтын гэрээг бүрэн хийгээгүй, үүрэг даалгаврын биелэлтийг тооцох ажил хангалтгүй байна.	13
2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээнд Зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан ажил байхгүй байна.	15
2.3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд тавих хөндлөнгийн хяналтууд сайжирч хууль эрхзүйн хүрээнд зохих хяналтуудыг хэрэгжүүлсэн ба хяналтын байгууллагуудын уялдаат байдал нэмэгдсэн байна.	16
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ЗАРДЛЫГ ГЭРЭЭНД БҮРЭН ТУСГАН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БОЛОВЧ ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД ОЛГОГДСОН САНХҮҮЖИЛТИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.....	17
3.1. Аймгаас орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС, авто замын сангаас хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлыг хууль тогтоомж, холбогдох журамд нийцүүлэн гэрээнд бүрэн тусгаагүй, сумдын түвшинд энэхүү зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байна.	17
3.2. Захиалагчийн хяналтын зардлыг гэрээний дагуу бүрэн санхүүжүүлээгүй бөгөөд хоорондын тооцоог хийж баталгаажуулаагүй байна.....	22
3.3. Захиалагчийн хяналтын зардлыг батлагдсан зориулалтын дагуу зарцуулсан байна.	25
3.4. Захиалагчийн хяналтын зардлын зарцуулалтыг ил тод мэдээлсэн байна.....	27
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	28
ДҮГНЭЛТ	30
ЗӨВЛӨМЖ	31
Хавсралт 1. Барилга байгууламж барих, угсралт, суурилуулалт, засвар, авто зам болон замын байгууламжийн барих, засварлах ажлуудын захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд тусгасан байдал, хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомж болон дүрэм, журам	33
Хавсралт 2. Сумдын 2023-2025 оны ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга, авто замын байгууламж, засварын төсөл, арга хэмжээнээс захиалагчийн хяналтын зардал суутгасан төсөөлөл. /мян.төг/	36
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	38

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БУА	Барилга угсралтын ажил
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗЗБНБД	Зам замын байгууламжийн норм бодох дүрэм
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МТТАТ	Малын тоо толгойн албан татвар
МУЗГ	Монгол улсын засгийн газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ОНТХО, АЗС, ОНХС -с хэрэгжүүлсэн ТАХ. 2023-2025 он /сая.төг/	6
Хүснэгт 2. ОНТХО-с хэрэгжүүлсэн ТАХ-с суутгасан захиалагчийн хяналтын зардал /сая.төг/.....	6
Хүснэгт 3. ГХБХБГ-н захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч, АЗДТГ-н ХБТХОХ-н гүйцэтгэлийг хянах эрх бүхий албан хаагчийн тоо. 2023-2025 он	10
Хүснэгт 4. Аудитын явцад ирүүлсэн захиалагчийн хяналтын судалгаа	14
Хүснэгт 5. ОНТХ-өөр 2023-2025 онд хэрэгжсэн ТАХ-ний захиалагчийн хяналтын зардлын тооцоолол	18
Хүснэгт 6. Захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд зохих хувь хэмжээгээр тусгасан ТАХ тоо	19
Хүснэгт 7. Захиалагчийн хяналтын зардлын хэмжээг зохих хувиар тусгаагүй аймгаас хэрэгжүүлсэн ТАХ-ний гэрээний жагсаалт /мян.төг/	19
Хүснэгт 8. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-үүдээс захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд тусгах боломжтой байсан ажлын тоо, зардал.....	21
Хүснэгт 9. Захиалагчийн хяналтын зардлын 1001000051414 дансны орлого, зарлага /2023-2025 он мян.төг/	22
Хүснэгт 10. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023-2025 онд үндсэн гэрээнд захиалагчийн хяналтын зардлыг тусгасан ТАХ-ны мэдээлэл /мян.төг/	23
Хүснэгт 11. Захиалагчийн хяналтын нийт зардлаас олгосон санхүүжилт /мян.төг/.....	24
Хүснэгт 12. ГХБХБГ-н 2023-2025 оны захиалагчийн хяналтын зардлын төлөвлөлт, зарцуулалт /мян.төг/	25
Хүснэгт 13. АЗДТГ-н захиалагчийн хяналтын зардлын зарцуулалт. 2023-2025 он /мян.төг/	26
Хүснэгт 14. Захиалагчийн хяналтын зардлын зарцуулалт. 2023-2025 он /мян.төг/.....	27

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дүрслэл 1. Захиалагчийн хяналтын судалгаа.....	12
--	----

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хужирт сумын 1, 2 дугаар сургуулийн дотуур байрны засварын ажлын даалгаварт байх газардуулгын утас холбоогүй	15
---	----

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит нэр:	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хяналтын тогтолцоо, захиалагчийн хяналтын үр нөлөө
Аудитын код:	ӨВА-2026/36/ШТА-НА
Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн тушаалаар баталсан "Аудитын сэдэв батлах тухай" А/173, "Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/179 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн аудитыг хийж гүйцэтгэв.
Аудитын зорилт:	<p>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хяналтын тогтолцоо, захиалагчийн хяналтын үр нөлөөнд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүгнэлтийг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.</p> <p>Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • <i>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хяналтын тогтолцоо оновчтой, бүрэн төлөвшсөн эсэх;</i> • <i>Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээнд хэрэгжүүлэх хяналтыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;</i> • <i>Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн захиалагчийн хяналтын зардлыг журмын дагуу төлөвлөн, зарцуулсан эсэх.</i>
Аудитын хамарсан хүрээ:	<p>Аудитад аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын хэлтсүүд, ГХБХБГ зэрэг байгууллагуудыг хамруулсан.</p> <p>Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газраас “Орон нутгийн төсвийн 2023, 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023, 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө”-нд хийж гүйцэтгэсэн аудитын дүгнэлт судалгаанд тулгуурлан; 2023-2025 онд ОНТХО, ОНХС, Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний захиалагчийн хяналтын гэрээ, захиалагчийн хяналтын зардлын зарцуулалт, бусад холбогдох нотлох баримт материал болон тооцоо, судалгаатай холбоотой мэдээллүүдэд үндэслэсэн.</p> <p>Өвөрхангай аймаг, Арвайхээр, Хархорин, Бат-Өлзий, Уянга, Хужирт, Баян-Өндөр, Гучин-Ус, Баянгол, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Төгрөг, Сант сумдад ОНТХО, ОНХС, Авто замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэн 2023, 2024, 2025 онуудад хийгдсэн ТАХ-үүдийн хяналтын тогтолцоо, захиалагчийн хяналтын зардлыг тайлан болон гүйцэтгэлтэй уялдуулан үзэж дүгнэлт гаргасан.</p>
Аудитад хэрэглэсэн арга зүй:	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын

	<p>стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал” болон бусад заавар, аргачлалын дагуу аудитын зорилго, зорилт, хөтөлбөр горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:</p>	<p>Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • <i>Барилгын тухай хууль,</i> • <i>Газрын тухай хууль,</i> • <i>Авто замын тухай хууль</i> • <i>Эрчим хүчний тухай хууль</i> • <i>Хот байгуулалтын тухай хууль</i> • <i>Шилэн дансны тухай хууль</i> • <i>Засгийн газрын 2018 оны 316 дугаар тогтоол,</i> • <i>Засгийн газрын 2017 оны 170-р тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"</i> • <i>Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"</i> • <i>Засгийн газрын 2021 оны 343-р тогтоолоор баталсан "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэх, хуулийн этгээдэд тавигдах шаардлага"</i> • <i>Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны "Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрөл батлах" тухай 83 дугаар тушаал,</i> • <i>Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 30-р тогтоолоор баталсан "Барилгын төсөв зохиох дүрэм"</i> • <i>Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх" журам,</i> • <i>Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 256 дугаар тушаалаар баталсан "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм ЗЗБНБД 81-013-2019"</i> • <i>МУЗГ-н 2019 оны 312-р тогтоолоор баталсан "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам",</i> • <i>Эрчим хүчний сайдын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 125 дугаар тушаалаар "Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам"</i> • <i>Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"</i> • <i>Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"</i> • <i>Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх гэрээ, гэрээний нөхцөл</i> • <i>Аймгийн ИТХ-аас гарсан заавар, журам</i>

	<ul style="list-style-type: none"> Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, стандарт
Аудит хийх багийн бүрэлдэхүүн	Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор О.Батжаргал хянан удирдаж, аудитын менежер П.Хорлоосүрэн үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ө.Ринчинмядаг, аудитор Р.Энхзул, Д.Очирбат нар 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс 4 дүгээр сарын 24-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл:

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газраас Автозамын сангийн 2021-2023 оны хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн; ОНХС, ОНТХО-ын 2023, 2024 оны зарцуулалтад хийсэн аудитын дүгнэлтээр захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үе шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна гэсэн зөрчлүүд удаа дараа давтан илэрсэн. Төрийн аудитын тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам, Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам; Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам зэрэг бусад холбогдох бусад дүрэм, журамд заасны дагуу хөндлөнгийн хяналтууд хийгдэхээр тусгагдсан.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, автозамын сан, ОНХС-аас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нийт зардлыг аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор 2023 онд 21,169.3 сая, 2024 онд 27,912.6 сая, 2025 онд 28,462.1 сая төгрөгөөр тус тус баталсан. Эдгээр эх үүсвэрээс санхүүжсэн ТАХ-ний тоо, зарцуулалтын гүйцэтгэлийн дүнг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. ОНТХО, АЗС, ОНХС -с хэрэгжүүлсэн ТАХ. 2023-2025 он /сая.төг/

№	Үзүүлэлт	2023 он		2024 он		2025 он	
		ТАХ тоо	Гүйцэтгэл	ТАХ тоо	Гүйцэтгэл	ТАХ тоо	Гүйцэтгэл
1	ОНХС /аймаг, сум нийт дүнгээр/	326	12,762.9	283	10,889.9	329	12,746.03
2	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	21	1,604.1	47	2,601.6	24	3,128.64
3	Авто замын сан	5	562.8	7	703.1	4	1,038.19
Нийт зарцуулалт		352	14,929.8	337	14,194.6	357	16,912.86

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын аудитын тайлангаас

Аймгийн хөрөнгө оруулалтын зардлаас хэрэгжүүлсэн ТАХ-ний санхүүжилтээс захиалагчийн хяналтын зардлыг 2023 онд 101.2 сая, 2024 онд 73.78 сая, 2025 онд 112.98 сая төгрөгийг тус тус суутгасан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. ОНТХО-с хэрэгжүүлсэн ТАХ-с суутгасан захиалагчийн хяналтын зардал /сая.төг/

№	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Он	Захиалагчийн хяналтын зардал суутгасан ТАХ-ний тоо	Нийт суутгасан захиалагчийн хяналтын зардал
1	Орон нутгийн хөрөнгө оруулалт	2023	14	20.40
	ОНХС		25	64.12
	Авто замын сан		2	16.73
Нийт дүн			41	101.25
2	Орон нутгийн хөрөнгө оруулалт	2024	13	21.91
	ОНХС		10	43.77
	Авто замын сан		2	8.09
Нийт дүн			25	73.78
3	Орон нутгийн хөрөнгө оруулалт	2025	18	42.61
	ОНХС		9	53.80
	Авто замын сан		3	16.58
Нийт дүн			30	112.98

Аудитаар **673.19** сая төгрөгийн 5 албан шаардлага, 13 зөвлөмж өгч; **673.19** сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 1 санхүүгийн бус үр өгөөж тооцов.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО БҮРДСЭН БОЛОВЧ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АЙМАГ, СУМДЫН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд хяналт хэрэгжүүлэхэд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам хоорондын уялдаа холбоо хангагдсан, бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27.-д ““орон нутгийн төсөв” гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг;” гэж заасан. Аймгийн ИТХ-ын тогтоолоор жил бүр аймгийн ОНХС, АЗС, орон нутгийн хөрөнгө оруулалт, их засварын зардлаас хэрэгжүүлэх ТАХ-г баталдаг. Эдгээр эх үүсвэрүүдээс баталж хэрэгжүүлдэг ТАХ-үүдийг төрлөөр нь харуулбал:

БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Барилгын тухай хуулиас

4.1.1."барилга байгууламж" гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг;

4.1.7."барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх" гэж барилга байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэн үндсэн бүтээц болон инженерийн шугам сүлжээг өөрчлөх, өргөтгөл, шинэчлэлт хийх үйл ажиллагааг;

АВТО ЗАМ, ДЭД БҮТЭЦ

Авто замын тухай,
Барилгын тухай,
Хот байгуулалтын тухай
хуулиудаас

4.1.1."авто зам" гэж тээврийн хэрэгсэл зорчиход зориулан барьсан замын байгууламж бүхий хатуу, хайрган хучилттай зам, гудамж, засаж, сайжруулсан болон ердийн хөрсөн замыг;

4.1.7."авто замын их засвар" гэж авто зам, замын байгууламжийн ашиглалтын ангилал, зэрэглэл, ашиглалтын түвшинг дээшлүүлж, сайжруулах зорилгоор тогтоосон хугацаанд хийх барилгын ажлыг;

4.1.33."инженерийн дэд бүтэц" гэж авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын доор, дээр байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийг;

3.1.10."инженерийн дэд бүтэц" гэж эрчим хүч, цэвэр, бохир усны болон зам, замын байгууламж, тээвэр, харилцаа холбооны шугам сүлжээ, барилга байгууламжийг;

ИХ ЗАСВАР, ТОХИЖИЛТ

Барилгын тухай хуулиас

4.1.5."барилга байгууламжийг засварлах, тоноглох" гэж ашиглалтын хэвийн нөхцөлийг дээшлүүлэх зорилгоор барилга байгууламжийг бүхэлд нь буюу хэсэгчлэн засварлаж, нэмэлт болон тусгай тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг;

4.1.28."засварын ажил" гэж барилгын үндсэн хийц, бүтээцийг өөрчлөхгүйгээр барилга байгууламжийг засварлах, түүнд суурилуулсан цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, механик тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг бууруулахгүйгээр ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор элэгдэж хуучирсан, эвдэрсэн тоног төхөөрөмжийг солих зэрэг үйл ажиллагааг;

4.1.25."гадна тохижилтын ажил" гэж барилга байгууламжийн гаднах талбайн ногоон байгууламж, автозам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, уран барилгын жижиг хэлбэр, гэрэлтүүлэг зэргийг барьж байгуулах үйл ажиллагааг;

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

"тоног төхөөрөмж" гэж төрийн болон орон нутгийн өмчид бүртгэгдэх хөрөнгө оруулалтын шинж чанартай авто машин, машин, тавилга, компьютер, техник хэрэгсэл, багаж зэмсгийг;

ЗУРАГ ТӨСӨВ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, БУСАД

Барилгын тухай хууль
Авто замын тухай хууль

4.1.29."зөвлөх үйлчилгээ" гэж барилгын үе шатны ажил гүйцэтгэх, норм, нормативын баримт бичиг боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн сонголт, механик-автоматжуулалт, тохируулга, зүгшрүүлэх, чанар аюулгүй байдлын түвшин, төлөв байдлыг тогтооход шаардлагатай мэргэжил, тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг;

4.1.30."зураг төсөл" гэж барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг;

4.1.18."зураг төсөл" гэж авто зам, замын байгууламжийг барих, засварлах, шинэчлэхэд шаардагдах хайгуул, геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, байгаль орчны судалгаа, нарийвчилсан зураг, техникийн шаардлага, өртгийн тооцооны нэгдсэн баримт бичгийг;

Дээрх 5 төрлөөс хууль журмын дагуу барилга байгууламж, авто зам, дэд бүтэц, их засвар, тохижилтын ажилд захиалагчийн хяналт хийгддэг.

Захиалагчийн хяналт гэдэг нь хөрөнгө оруулагчаас мэргэжлийн байгууллагаар төлөөлүүлэн төслийн явц, чанар, аюулгүй байдалд тавих хяналт, удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааг хэлнэ. */эх сурвалж: Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагыг Урьдчилан тандан судалсан тайлан/*

Монгол Улсад захиалагчийн хяналтын үйл ажиллагааг дараах хууль, журмуудаар зохицуулдаг.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан **"Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"**-д хяналт, захиалагчийн хяналттай холбоотой захиалагчийн чиг үүрэг, захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг, санхүүжилтийн ерөнхий зохицуулалтыг зааж өгсөн.

<p>БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬ</p>		<p>БАРИЛГЫН АЖЛЫН ЗАХИАЛАГЧИЙН ДҮРЭМ</p>
<p>37 дугаар зүйлийн 37.1.4. “барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах”; 37.2-т “Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.”</p>		<p>3 дугаар зүйлийн 3.4. “Захиалагч барилгын ажлын явц, үе шатанд тавих хяналтыг гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч болон барилгын үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдтэй хамтран гэрээний үндсэн дээр өдөр, сар, улирал бүрээр гүйцэтгэнэ.”, 3.12. “Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.”</p>
<p>АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬ</p>	<p>АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ</p>	
<p>4 дүгээр зүйлийн 4.1.26-д ““техник, технологийн хяналт” гэж авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг батлагдсан зураг, төсөв, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах ажиллагааг”, 21 дүгээр зүйлийн 21.1. “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.”</p>	<p>2 дугаар зүйлийн 2.1. “Зөвлөх нь замын барилгын ажлыг батлагдсан зураг, төсөв, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах, төслийн явцын тайлан мэдээ гаргах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.”</p>	

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3.5. “захиалагчийн хяналт хэрэгжүүлэх этгээд, хэлбэр;”-ийг гэрээнд тусгана гэж заасан.

Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам – 1 дүгээр зүйлийн 1.5-д “Эрчим хүчний яамнаас эрх олгосон байгууллага барилгын үе шатны ажилд захиалагчийн

техникийн хяналтыг хэрэгжүүлнэ.”, 4 дүгээр зүйлийн 4.2.1.-д захиалагч нь “барилга байгууламж барих ажлын явцад энэ журмын 4.1.1-д заасны дагуу төлөвлөгөөт хуваарийн дагуу хяналт тавих ба барилга байгууламжийн ажилд зураг төсөл, техникийн нөхцөл, стандарт зөрчвөл тухайн ажлыг зогсоох, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах,” гэж заасан.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан **"Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"**-д ТАХ-ний гүйцэтгэлд тавих хяналтыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

- 3.3. Аймаг, нийслэлийн Засаг даргын чиг үүрэг: -3.3.3.ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 3.4. Сум, дүүргийн Засаг даргын чиг үүрэг:-3.4.3.Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

МУЗГ-н 2019 оны 312-р тогтоолоор баталсан **"Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"**-д ТАХ-ний гүйцэтгэлд тавих хяналтыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

4.1. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга улс, нийслэл, орон нутгийн авто замын сангийн хөрөнгийг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнахтай холбогдсон үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн тус тус эрхлэн явуулна.

Аймгийн ОНХС, авто замын сан, орон нутгийн хөрөнгө оруулалт, их засварын зардлаас хэрэгжүүлж буй барилга байгууламж, дэд бүтэц, их засвар, тохижилтын ажлуудад Барилгын тухай хууль, Барилгын ажлын захиалагчийн дүрэм болон бусад холбогдох дүрэм, журмуудыг мөрдлөг болгон захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ гүйцэтгэж байна.

Харин авто замын байгууламж, засварын ажлуудад Авто замын тухай хууль, Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам болон бусад холбогдох дүрэм, журмуудыг мөрдлөг болгон захиалагчийн хяналтыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ гүйцэтгэж байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ТАХ-үүдийн хяналтыг сумаас хэрэгжүүлж байгаа бөгөөд нарийн мэргэжил шаардсан томоохон ажлуудын захиалагчийн хяналтыг гэрээний үндсэн дээр аймгийн ГХБХБГ-аар хийлгэх бүрэн боломжтой, энэ тухай холбогдох хууль, журамд тодорхой тусгасан байна.

1.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймгаас хэрэгжүүлж буй ТАХ-нд хяналт тавьж буй байгууллагуудад нарийн мэргэжлийн хүний нөөцөөр хангагдсан боловч сумдад мэргэжлийн боловсон хүчин байхгүй, аймаг сумдын харилцан уялдаат байдал дутмаг байна.

Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-нд тавих захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ-ын барилга, хот байгуулалтын хэлтэс болон аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс хэрэгжүүлж байна. Тус байгууллагууд дараах үндсэн чиг үүргүүдийг гүйцэтгэдэг. Үүнд:

ГХБХБГ нь барилгын салбарын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, орон нутагт баригдах барилга байгууламжийн зураг төсөлд хяналт тавих, барилгын байгууллагууд, ААН-ийн үйл ажиллагаанд Барилгын тухай болон бусад хууль тогтоомж, барилгын норм дүрмийн хэрэгжилтийг хангуулах, инженерийн шугам сүлжээний ашиглалт, хамгаалалт, шинэчлэлт, өргөтгөл засварын ажилд санал дүгнэлт гарган хяналт тавих, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах, НАА-н байгууллагуудыг бодлого чиглэлээр хангах, барилгын материалын үйлдвэрлэлд мэргэжлийн дэмжлэг үзүүлж арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь Монгол Улсын хөгжлийн бодлого, аймгийн 5 жилийн үндсэн чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигт үндэслэн аймгийн эдийн засгийн хөгжлийн стратеги, бодлогыг төлөвлөх, үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, дэд бүтэц, (эрчим хүч, зам, тээвэр, харилцаа холбоо, шуудан), хот байгуулалт, архитектур, төлөвлөлт, газрын харилцаа, байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, хөрөнгө оруулалт, орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг асуудлаар аймгийн хэмжээнд баримтлах бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага.

Тус 2 байгууллагын хувьд үндсэн орон тоонд 2023-2025 онуудад тогтвор суурьшилтай ажилласан, ГХБХБГ-ын гэрээт инженерүүдийн өнгөрсөн 3 жилийн хугацаанд 1 удаа хөдөлгөөн гарсан, ХБТХОХ-ийн хувьд 2023 онд даргын үүргийг мэргэжилтэн түр орлон гүйцэтгэж байгаад 2024 оноос бүрэн орон тоогоор ажиллаж эхэлсэн байна. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч албан хаагчдын тоог 2023-2025 оны байдлаар харуулбал. Үүнд:

Хүснэгт 3. ГХБХБГ-н захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч, АЗДТГ-н ХБТХОХ-н гүйцэтгэлийг хянах эрх бүхий албан хаагчийн тоо. 2023-2025 он

№	Байгууллагын нэр	Огноо	Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий албан хаагч /үндсэн орон тоо/		Хяналт хэрэгжүүлэх эрх бүхий гэрээт ажилтан	
			Батлагдсан бүтэц, орон тоо	Ажиллаж буй	Батлагдсан бүтэц, орон тоо	Ажиллаж буй
1	Аймгийн ГХБХБГ-ын барилга, хот байгуулалтын хэлтэс	2023	3	3	-	-
2		2024	3	3	2	2
3		2025	3	3	3	3
№	Байгууллагын нэр	Огноо	Гүйцэтгэлийг хянах эрх бүхий албан хаагч /үндсэн орон тоо/		Хяналт хэрэгжүүлэх эрх бүхий гэрээт ажилтан	
			Батлагдсан бүтэц, орон тоо	Ажиллаж буй	Батлагдсан бүтэц, орон тоо	Ажиллаж буй
1	Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	2023	3	2	-	-
2		2024	3	3	-	-
3		2025	3	3	-	-

* Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий, гүйцэтгэлийг хяналт хэрэгжүүлэх эрх бүхий гэдэг нь тусдаа ойлголтууд юм

Аймгийн ГХБХБГ-ын барилга, хот байгуулалтын хэлтсийн хувьд батлагдсан орон тоо-5, үүнээс захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий 3 албан тушаалтан байдаг. Мөн тухайн оны захиалагчийн хяналтын зардлын санхүүжилтээс хамааран 2-3 гэрээт хяналтын инженерийг ажиллуулж байна. Үүнд:

- Хэлтсийн дарга
- Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
- Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Гэрээт хяналтын инженер /2-3/

Үндсэн орон тоонд бүтцийн өөрчлөлт ороогүй. Аймгийн Засаг даргын 2024 оны А/49 дүгээр захирамжаар 2 гэрээт инженер, 2025 оны А/04 дүгээр захирамжаар 3 гэрээт инженер болгон нэмэгдүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 360 дугаар тогтоолоор батлагдан; Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын баталгаажуулсан албан тушаалын тодорхойлолтод дээрх албан тушаалтнуудын гүйцэтгэх чиг үүрэгт “Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга, байгууламжийг шинээр барих, өргөтгөх, их засварын ажилд захиалагчийн хяналт хийх” гэж заасан.

Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хувьд батлагдсан орон тоо нийт 13, үүнээс орон нутгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийг хянах үүрэг бүхий 3 албан тушаалтан байна. Үүнд:

- Хэлтсийн дарга
- Барилгын зураг төсөл, гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн
- Дэд бүтцийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Үндсэн орон тоонд бүтцийн өөрчлөлт ороогүй.

Аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар батлагдсан дээрх албан тушаалтнуудын гүйцэтгэх чиг үүрэгт “Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай болон бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах”, “Хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийг хянаж, хүлээж авах” гэж заасан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 31-ны өдрийн 256 дугаар тушаалаар баталсан **“АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГА, ЗАСВАРЫН АЖЛЫН ТӨСӨВ БОДОХ НОРМ ЗЗБНБД 81-013-2019”**-д 5 дугаар зүйлийн 5.4.6.-д¹ заасны дагуу 5.0 тэрбум төгрөг хүртэлх төсөвт өртөг бүхий авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд Техник, технологийн хяналтыг захиалагч байгууллага нь хэрэгжүүлнэ гэж заасны дагуу ХБТХОХ хяналтыг хэрэгжүүлж байна.

Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын захиалагчийн хяналтыг ХБТХОХ-ийн авто замын хяналтын улсын ахлах байцаагч хийдэг. Тус байцаагчийн хувьд захиалагчийн хяналтыг хийх эрх бүхий албан тушаалтан биш бөгөөд албан тушаалын тодорхойлолтод захиалагчийн хяналт хийнэ гэсэн нарийн заалт тусгагдаагүй; хариуцсан салбарын хяналт шалгалт хийх, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй боловч авто замын захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх боломжтой мэргэжлийн боловсон хүчин гэдэг талаасаа хяналтыг хийж байна.

Тус 2 байгууллагын хувьд хяналтыг хэрэгжүүлэгч албан хаагчид нь тухайн албан тушаалд 2-12 жилийн хугацаанд ажилласан туршлагатай бөгөөд батлагдсан албан тушаалын тодорхойлолтын шаардлагад бүрэн нийцсэн байна. Захиалагчийн хяналтыг дараах үндсэн мэргэжил бүхий албан хаагчид хийж байна. Үүнд:

- Дулааны инженер
- Иргэний ба үйлдвэрлэлийн барилгын инженер
- Дулааны цахилгаан станц механик инженер
- Цахилгааны инженер
- Авто замын барилгын инженер
- Хот ба бүс нутгийн төлөвлөлт

Аймгийн ТЕЗ-ийн зүгээс хөрөнгө оруулалтын ТАХ-үүдийн тоо нэмэгдэх үед хүний нөөцийн хүрэлцээтэй байдлыг давхар харгалзан үзэж, гэрээт инженерүүдийн цалин хөлс, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах талаар анхааран үзэх шаардлагатай юм.

Арвайхээр, Хархорин сумдын хувьд Хотын захирагчийн ажлын албанд архитекторын орон тоотойгоор ажиллаж тухайн суманд хэрэгжсэн ТАХ-үүдийн захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ирсэн байна. Бусад сумдын хувьд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй бүх төрлийн ТАХ-ний захиалагчийн хяналтыг сумдын ЗДТГ-ын албан хаагчид дотоод нөөц боломжоороо хэрэгжүүлж ирсэн. Нарийн мэргэжлийн инженерийн хяналт шаардлагатай ажилд мэргэжлийн бус хүн хяналт тавих нь зураг төсвийн дагуу барилга байгууламж баригдахгүй байх, ажлыг чанаргүй гүйцэтгэгдэхэд нөлөөлж байна

Сумдын хувьд барилга, авто замын байгууламж, засварын ажлуудад захиалагчийн хяналт хэрэгжүүлэх мэргэжлийн боловсон хүчин байхгүй тул хүндрэлтэй байдаг. Засгийн газрын 2017 оны 170-р тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ын 2 дугаар зүйлийн 2.8-д "Захиалагч Барилгын тухай хуулийн 37.1.4-т заасан барилгын үе шатны ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулна.", 3 дугаар зүйлийн 3.12. "Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно." гэсэн заалтуудыг сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа ТАХ-д мөрддөггүй, энэ талаар сумдын удирдлага, албан хаагчдын мэдлэг ойлголт дутмаг байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан **"Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"**-н 2 дугаар зүйлийн 2.2.Төсвийн ерөнхийлөн захирагч дараах чиг үүргийг

¹ Техник, технологийн хяналтыг захиалагч байгууллага нь хэрэгжүүлэх 5.0 тэрбум төгрөг хүртэлх төсөвт өртөг бүхий авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд захиалагчийн хяналтын зардлыг төсвийн шууд зардлын дүнгээс 2 хувиар тооцох бөгөөд техник, технологийн хяналтын зардлыг давхардуулан тооцохгүй.

хэрэгжүүлнэ: 2.2.7-д “Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр тухайн салбарын судалгаа, дүн шинжилгээ хийх, танилцуулга, мэдээлэл бэлтгэх;” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч болон ХБТХОХ-с 2023-2025 онд сумдад нэгдсэн чиглэл, зөвлөмж өгөгдөөгүй, сумдад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаагүй байна. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ТАХ-үүдэд нэгдсэн дүн шинжилгээ, судалгаа хийгдээгүй, мэргэжлийн инженерийн хяналт шаардлагатай ажлуудыг тодорхойлоогүй, ГХБХБГ болон ХБТХОХ хооронд мэдээлэл солилцоо, харилцан уялдаат байдал дутмаг байна.

Орон нутгаас хэрэгжүүлж буй ТАХ-ний захиалагчийн хяналттай холбоотой асуулгыг аймаг болон 19 сумын ЗДТГ-ын захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй албан хаагчдаас авахад 149 хүн цахимаар хамрагдсан.


“Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхэд ямар хүндрэл бэрхшээл үүсдэг вэ?” гэсэн асуултад

Хяналт тавих төсөв байхгүй -**23.5% буюу 35 хүн**

Хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай боловсон хүчин байхгүй -**26.2% буюу 39 хүн**

Ажлын ачаалал их тул амждаггүй - **37.6% буюу 56 хүн**

Дүрслэл 1. Захиалагчийн хяналтын судалгаа



Аймаг, сумдаас хяналт тавьж буй байгууллагуудын боловсон хүчний нөөц боломжийг аймгийн ТЕЗ нарийн судлан үзэх шаардлагатай байна.

“Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналттай холбоотой нэмэлт саналтай бол бичнэ үү” гэсэн асуултад

- Мэргэшсэн хүн байхгүй болохоор юуг нь сайн муу хийсэн талаар мэддэггүй
- Энэ талаар ойлголт маш муу байна
- хяналт хийхэд мэргэжлийн боловсон хүчин дутмаг учир хяналтын үр дүн муу
- Энэ талаар огт мэдэхгүй тул мэдээлэл авах шаардлагатай юм байна. Хяналтын зардлын талаарх ойлголт байхгүй мэдэхгүй
- Захиалагчийн хяналтыг тогтворжуулах, түүнтэй холбогдолтой зардлыг төсөвт суулгах. Зарцуулалтыг ил тод байлгах
- эрх бүхий хяналт тавих албан хаагчид уялдаа холбоотой байх
- мэргэжлийн ур чадвартай мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллах
- Албан хаагчдыг сургалтад хамруулах
- Хяналтын төсөв батлуулдаггүй, гэрээнд заадаггүй, хяналт тавих ажилтны нөөц дутмаг, мэдлэг чадвар муу байдаг.
- Захиалагчийн хяналтын талаар мэдээлэл дутуу байдаг тийм учраас зардал төсөвт тусгадаггүй. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх шаардлагатай боловсон хүчин байхгүй байхгүй. Захиалагчийн хяналтын талаар сургалт авмаар байна. Хийгдэж байгаа ажлуудыг ЗДТГ, ИТХ-аас гаргасан ажлын хэсэг л хяналт тавьдаг.
- захиалагчийн хяналтын талаар мэдлэг дутмаг, мэдээлэл арга зүйгээр хангах шаардлагатай байна.

Дээрх асуулгаас дүгнэн үзэхэд сумдад мэргэжлийн боловсон хүчин байхгүй, сумдын албан хаагчдад захиалагчийн хяналтын талаар мэдлэг, мэдээлэл дутмаг, энэ талаар сургалт авах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д заасны дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-нд аймгаас бодлогоор судалгаа, дүн шинжилгээ хийгдээгүй, сумдад нэгдсэн байдлаар чиглэл, заавар өгөөгүй, төсвийн байгууллагууд нь уялдаагүй ажиллаж ирсэн байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ТАВИХ ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ САЙЖИРСАН БОЛОВЧ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

2.1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтын гэрээг бүрэн хийгээгүй, үүрэг даалгаврын биелэлтийг тооцох ажил хангалтгүй байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д зааснаар **захиалагч гэж төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 50 ба түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байна** гэж заасан. Тус журмаар захиалагч болон хяналт хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүргийг зааж өгсөн. Үүнд:

Журмын 4 дүгээр зүйлийн 4.2. “Захиалагчийн чиг үүрэг”	Журмын 4 дүгээр зүйлийн 4.4. “Захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг”
<p>4.2.2.1.төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг батлагдсан төсөвт өртөг, гэрээний нийт дүн, холбогдох норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарь, санхүүжилтийн хуваарийн дагуу тулган шалгаж, хянан баталгаажуулах;</p> <p>4.2.2.5.төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх;</p>	<p>4.4.1.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу техник, технологийн захиалагчийн хяналт хэрэгжүүлэх зөвшөөрлийг авсан байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>4.4.1.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн шилжүүлсэн эрхийн дагуу захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг төсөл, арга хэмжээ тус бүрээр захиалагчтай байгуулах;</p> <p>4.4.1.5.захиалагчийн техник, технологийн хяналтыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу мэргэжлийн түвшинд, чанартай, үр ашигтай, ил тод, нээлттэй болон хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэх;</p>
Журмын 5 дугаар зүйлийн 5.3.Хяналт	

5.3.1.Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ;

5.3.2.Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.4-т заасан нөхцөл байдал илэрсэн бол холбогдох мэдээллийг эрх бүхий улсын байцаагчид хүргүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр авч ажиллана;

5.3.6.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна;

5.3.7.Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга байгууламж, их засварын ажил бүрийг биечлэн хянаж, шалгах үүрэг бүхий захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь хяналт хийсэн тухай бүр тэмдэглэл үйлдэж, гүйцэтгэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар, түүний биелэлтийн талаар тэмдэглэж ажлын гүйцэтгэлд хавсаргаж, их засварын ажил дууссаны дараа санхүүжилтийн баримт бичгийн хамт захиалагчийн архивд хадгалуулна;

Аймгийн ГХБХБГ нь 2024 онд 19 ажилд хяналт тавихаар, 2025 онд 20 барилга байгууламжийн засварын ажилд техникийн хяналт гүйцэтгэхээр хавсралт бүхий нэгдсэн гэрээг аймгийн Засаг даргатай байгуулсан байна.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн хувьд зарим гадна байгууламж, холбоо сувагчлал, үерийн далан, авто замын засвар зэрэг ажлуудад хяналт хийж байгаа бөгөөд захиалагчийн хяналт хийх эрх бүхий хувь хүн, хуулийн этгээд байхгүй тул захиалагчийн хяналт хийх гэрээ хийгээгүй байна. Учир нь тус байгууллага нь захиалагчийн хяналт хийх бус ТАХ-ны гүйцэтгэлд хяналт тавих эрх бүхий байгууллага юм.

Аймгийн ГХБХБГ болон ХБТХОХ-ээс захиалагчийн хяналтыг дараах байдлаар хийсэн талаар аудитын явцад ирүүлсэн судалгаанд тусгасан байна. Үүнд:

Хүснэгт 4. Аудитын явцад ирүүлсэн захиалагчийн хяналтын судалгаа

№	Эх үүсвэр	Хяналт тавьсан байгууллага	2023 он		2024 он		2025 он		2023-2025 нийт дүн		
			Хэрэгжсэн ТАХ-ний тоо	Хяналт хийсэн ТАХ-ний тоо /судалгаагаар/	Хэрэгжсэн ТАХ-ний тоо	Хяналт хийсэн ТАХ-ний тоо /судалгаагаар/	Хэрэгжсэн ТАХ-ний тоо	Хяналт хийсэн ТАХ-ний тоо /судалгаагаар/	Хэрэгжсэн ТАХ-ний тоо	Хяналт хийсэн ТАХ-ний тоо /судалгаагаар/	
1	ОНТХО	ГХБХБГ	17	17	19	19	10	10	46	46	
2		ХБТХОХ	1	0	2	1	2	2	5	3	
3		Сум, байгууллага руу эрх шилжсэн	4		5		0		9		
4	ОНХС	ГХБХБГ	16	16	7	7	7	7	30	30	
5		ХБТХОХ	14	11	9	8	0	0	23	19	
6		Сум, байгууллага руу эрх шилжсэн	5		1		0		6		
7	Авто замын сан	ГХБХБГ							0	0	
8		ХБТХОХ	4	1	4	1	1	1	9	3	
9		Сум, байгууллага руу эрх шилжсэн	4		4		4		12		
Нийт дүн			ГХБХБГ	33	33	26	26	17	17	76	76
			ХБТХОХ	19	12	15	10	3	3	37	25
			Сум, байгууллага руу эрх шилжсэн	13		10		4		27	

Дээрх судалгаагаар аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 2023-2025 онд нийт 76 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хийсэн гэх боловч аудитаар 33 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтын хийсэн тайлан ирүүлсэн тул бусад ТАХ-д захиалагчийн хяналт хийсэн нь баримтаар нотлогдохгүй байна.

Судалгаагаар нийт ХБТХОХ-с 25 ТАХ-д хяналт хийсэн гэх боловч аудитаар мөн бүрэн нотлогдохгүй 9 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтын хийсэн тайлан ирүүлсэн тул бусад ТАХ-д захиалагчийн хяналт хийсэн нь мөн баримтаар нотлогдохгүй байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-н 5 дугаар зүйлийн 5.3.7-д заасны дагуу захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд гүйцэтгэгчид өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн тооцсон, биелэлтийн талаарх тэмдэглэл хангалтгүй, дотоод хяналт сул байна.

Зарим үүрэг даалгаврын биелэлтийг газар дээр нь очиж шалгах үед хийсэн ажил байхгүй байна.

Зураг 1. Хужирт сумын 1, 2 дугаар сургуулийн дотуур байрны засварын ажлын даалгаварт байх газардуулгын утас холбоогүй



АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4.1.1. "төсвийн ерөнхийлөн захирагчийн шилжүүлсэн эрхийн дагуу захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг төсөл, арга хэмжээ тус бүрээр захиалагчтай байгуулах;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, гэрээг нэгдсэн байдлаар хийсэн байна.
- Аймгийн ГХБХБГ, ХБТХОХ-ээс захиалагчийн хяналтад тавих дотоод хяналт сул байна. Захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь хяналт хийсэн тухай бүр тэмдэглэл үйлдэж, гүйцэтгэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар, түүний биелэлтийн талаар тэмдэглэж, ажлын гүйцэтгэлд хавсаргана гэж заасныг хэрэгжүүлээгүй, гүйцэтгэгчид өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн тэмдэглэл дутуу үйлдсэн байна.
- Аймгийн ГХБХБГ болон ХБТХОХ нь захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээнд Зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан ажил байхгүй байна.

Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29-д "зөвлөх үйлчилгээ" гэж барилгын үе шатны ажил гүйцэтгэх, норм, нормативын баримт бичиг боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн сонголт, механик-автоматжуулалт, тохируулга, зүгшрүүлэх, чанар аюулгүй байдлын түвшин, төлөв байдлыг тогтооход шаардлагатай мэргэжил, тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг"; 42 дугаар зүйлийн 42.2.-д "Энэ хуулийн 10.1.4², 10.1.5³-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээг заавал авна." гэж заасан.

Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17.-д "зөвлөх үйлчилгээ" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5.1.15-д заасныг;" гэж заасан.

² 10.1.4.өндөр төвөгшилтэй барилга байгууламж;

³ 10.1.5.онцгой төвөгшилтэй барилга байгууламж.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 228 дугаар тушаалаар батлагдсан Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журмын 1 дүгээр зүйлийн 1.2.-д “Төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх замын барилгын ажилд техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээг заавал хэрэгжүүлэх бөгөөд энэхүү журмыг баримтална.”;

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 31-ны өдрийн 256 дугаар тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм ЗЗБНБД 81-013-2019”-н 5 дугаар зүйлийн 5.4.6.-д “Техник, технологийн хяналтыг захиалагч байгууллага нь хэрэгжүүлэх 5.0 тэрбум төгрөг хүртэлх төсөвт өртөг бүхий авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд захиалагчийн хяналтын зардлыг төсвийн шууд зардлын дүнгээс 2 хувиар тооцох бөгөөд техник, технологийн хяналтын зардлыг давхардуулан тооцохгүй” гэж тус тус заасан байна.

Өвөрхангай аймагт 2023-2025 онд орон нутгийн төсөв, ОНХС, авто замын сангийн эх үүсвэрээр өндөр, онцгой түвэгшлийн ангилалд хамаарах барилга байгууламж баригдаагүй; 5 тэрбумаас дээш төсөвт өртөгтэй авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажил хийгдээгүй тул зөвлөх үйлчилгээг аваагүй захиалагч тал болох аймгийн ХБТХОХ, ГХБХБГ-аас хяналтыг хэрэгжүүлж ирсэн байна.

2.3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд тавих хөндлөнгийн хяналтууд сайжирч хууль эрхзүйн хүрээнд зохих хяналтуудыг хэрэгжүүлсэн ба хяналтын байгууллагуудын уялдаат байдал нэмэгдсэн байна.

ОНТХО-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд аймаг, сумын ИТХ, Төрийн аудитын байгууллага, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагууд хөндлөнгийн хяналт хийх эрхзүйн зохицуулалттай байна. Үүнд:



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Төрийн аудитын байгууллагаас жил бүр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд аудит хийж байна. Төрийн аудитын байгууллагын доорх аудитын тайлангуудын дүгнэлтээр ихэнх сумдын ИТХ-н хяналт хангалтгүй байсан байна.

Тайлан	Тайлантай танилцах хаяг
ОНХС -ийн 2023, 2024 оны тайлан	https://audit.mn/audit/report_detail/43542
ОНХС -ийн оны тайлан	https://audit.mn/audit/report_detail/39642
АЗС -ийн 2021-2023 оны тайлан	https://audit.mn/audit/report_detail/35247
ОНТХО -ийн 2023 оны тайлан	https://audit.mn/audit/report_detail/43543
ОНТХО -ийн 2024 оны тайлан	https://audit.mn/audit/report_detail/39549

САНГИЙН ЯАМ

Сангийн яамны Дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалт, үнэлгээний газраас 2025 онд Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023-2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн байна.

АЙМАГ, СУМДЫН ИТХ-ЫН ХЯНАЛТ

Аймгийн ИТХ-аас орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй /2023 онд-1, 2024 онд-14, 2025 онд-5 нийт 20/ ТАХ-д хяналт шалгалт хийсэн байна. Тодруулбал 2023–2024 онд ТАХ-д хийсэн хяналтын дүнг аймгийн ИТХ-ын зөвлөлийн хуралдаанд танилцуулж байсан бол 2025 оны хяналтаар 2023 онд хийгдсэн боловч бүрэн ашиглалтад ороогүй ТАХ-д дахин хяналт хийж, аймгийн ИТХ-ын тогтоолоор Засаг даргад холбогдох арга хэмжээ авч, биелэлтийг тайлагнах үүрэг өгсөн байна. Үүнд:

1. Гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлдэггүй, гүйцэтгэл удаашруулдаг аж ахуйн нэгжүүдийг дараагийн Тендер сонгон шалгаруулалтад оролцуулахгүй байх чиглэлээр хууль дүрмийн хүрээнд холбогдох арга хэмжээг авах;
2. Захиалагч талын хяналтыг сайжруулах, санхүүжилтийг хуваарийн дагуу олгох, гэрээ байгуулсан талууд үүргээ зөрчсөн тохиолдолд холбогдох албан тушаалтан, хариуцагчид хариуцлага тооцож ажиллах;
3. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний зураг төсвийг хийлгэхдээ захиалагчийн зүгээс мэргэжлийн түвшинд хяналт тавьж, алдаатай зураг төсвийг хүлээж авахгүй байхад анхаарч ажиллах; гэсэн байна.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

Өвөрхангай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2023 онд– 4 сумын ОНХС, 2024 онд 19 сумын МТТАТ-н орлого бүрдүүлэлт, зарцуулалт, 2025 онд– 5 сумын ОНХС-д хяналт шалгалт хийсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хувьд хамруулах сумын тоо өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ИРГЭД, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

Орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагаар хөндлөнгийн хяналт хийлгээгүй байна.

Төрийн аудитын байгууллага, Сангийн яам, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар аудит, хяналт шалгалтаар тогтмол мэдээллээ солилцож хэвшээд байна. Уялдаат байдал сайжирч мэдээлэл сайн солилцсоноор аудит, хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд давхардуулж акт, албан шаардлага тавихгүй байх нөхцөл бүрдсэн бөгөөд цаашлаад алдаа зөрчил буурах боломжтой.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ЗАРДЛЫГ ГЭРЭЭНД БҮРЭН ТУСГАН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БОЛОВЧ ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД ОЛГОГДСОН САНХҮҮЖИЛТИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

3.1. Аймгаас орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС, авто замын сангаас хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлыг хууль тогтоомж, холбогдох журамд нийцүүлэн гэрээнд бүрэн тусгаагүй, сумдын түвшинд энэхүү зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Барилга байгууламж барих, угсралт, суурилуулалт, засвар, авто зам болон замын байгууламжийн барих, засварлах ажлуудын захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд тусгасан байдал, хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомж болон дүрэм, журамд заасан заалтын дагуу үе шат бүрээр нь харуулбал. Үүнд:

Үе шатны ажил	Хэн хэрэгжүүлэх	Хийгдэх ажил	Хэрэгжилт
Төсөл арга хэмжээний худалдан	Захиалагч	Худалдан авах ажиллагааны баримт бичиг боловсруулахдаа	Худалдан авах ажиллагааны баримт бичигт захиалагчийн

авах ажиллагааг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> ■ Үнэлгээний хороо 	захиалагчийн хяналт хэрэгжүүлэх этгээд, хэлбэрийг тодорхой болгоно.	хяналт хэрэгжүүлэх этгээд, хэлбэрийг тодорхойлохгүй байна.
Гүйцэтгэгч тендерийн баримт бичиг боловсруулах, төсөв боловсруулж сонгон шалгаруулалтад оролцох	<ul style="list-style-type: none"> ■ Худалдан авах ажиллагаанд оролцогч 	Холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу ажил гүйцэтгэхэд шаардлагатай төсөв боловсруулж худалдан авах ажиллагаанд оролцоно. Барилга байгууламж, авто зам, замын байгууламж, засварын ажил бол төсөвт өртгийн нэгдсэн товчоонд захиалагчийн хяналтын зардал заавал байна.	Оролцогч төсөвт өртгийн нэгдсэн товчоо боловсруулах төсөв боловсруулах дүрэм, нормыг бүрэн мөрдөхгүй байна.
Гүйцэтгэгчийг шалгаруулж ажил гүйцэтгэх гэрээ байгуулах	<ul style="list-style-type: none"> ■ Захиалагч ■ Гүйцэтгэгч 	Холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу ажил гүйцэтгэх гэрээ байгуулах ба гэрээнд захиалагчийн хяналтын зардал тусгагдсан байна.	Аймгийн хувьд ажил гүйцэтгэх гэрээнд захиалагчийн хяналтын зардал тусгаж байгаач гүйцэтгэгчээс ирүүлсэн зөрүүтэй дүнг, гэрээ боловсруулах үед арифметик алдаа гаргаж ирүүлсэн дүнгээс өөр дүн бичиж гэрээ байгуулах асуудал гарч байна. Сумдын хувьд гэрээнд захиалагчийн хяналтын зардлыг тусгахгүй байна.
Захиалагчийн хяналт хийх гэрээ байгуулах	<ul style="list-style-type: none"> ■ Захиалагч ■ Захиалагчийн хяналт хийх этгээд 	Захиалагчийн хяналт хийх эрх бүхий байгууллага, албан тушаалтантай захиалагчийн хяналт хийх гэрээ байгуулна. Гэрээнд төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хийх хуваарь, давтамж, хяналт хийх этгээдийн эрх, үүргийг тусгана.	Аймгийн хувьд захиалагчийн хяналтын гэрээ байгуулж байгаач төсөл, арга хэмжээ бүрээр байгуулахгүй, сумдын хувьд огт байгуулахгүй байна.
Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> ■ Захиалагч ■ Захиалагчийн хяналт хийх этгээд 	Ажлын явцад ажлыг хугацаандаа чанартай хийж гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт хийж зөрчил дутагдлыг арилгуулах /буруу хийсэн ажлыг засуулах/, зураг төслийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт хийнэ.	Захиалагчийн хяналт хэрэгжүүлж байгаа байгууллага гэрээний дагуу бүрэн ажиллахгүй байна.
Төсөл, арга хэмжээг хүлээн авах	<ul style="list-style-type: none"> ■ Төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс 	Захиалагчийн хяналтаар үүрэг даалгавар өгөгдсөн, тухайн үүрэг даалгавар бүрэн биелэгдсэн эсэхийг заавал баталгаажуулна.	Ажил хүлээн авах комисс захиалагчийн хяналтаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн баталгаажуулахгүй байна.

Дээрх хүснэгтэд дурдсан үе шатны ажлуудад хяналт хэрэгжүүлэх холбогдох хууль, журмын дэлгэрэнгүй заалтыг **ХАВСРАЛТ-1** харах.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” -ийн 4 дүгээр зүйлийн 4.7.3.-д зааснаар Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хувьд захиалагчийн хяналтын зардлыг дараах хувь хэмжээгээр тооцож заавал гэрээнд тусгана.

Барилга байгууламжийн хувьд	Зам, замын байгууламжийн хувьд
Барилга байгууламжийн ажлын хувьд барилгын төвөгшилөөс хамаарч ихдээ 5%, багадаа 2% байна.	Зам, замын байгууламжийн хувьд зам, гүүрний уртаас хамаарч ихдээ 5%, багадаа 0.4% байна.

Аймаг-Аймгийн хэмжээнд 2023-2025 онуудад орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдээс барилга болон авто замтай холбоотой захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд тусган хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг авч үзвэл:

Хүснэгт 5. ОНТХ-өөр 2023-2025 онд хэрэгжсэн ТАХ-ний захиалагчийн хяналтын зардлын тооцоолол

№	Аймаг, сумдын нэр	Захиалагчийн хяналтын зардал тусгах боломжтой ТАХ-ний тоо	Гэрээнд захиалагчийн хяналтын зардал тусгасан ТАХ тоо	Хувь
---	-------------------	---	---	------

1	Аймаг	135	101	74.8
2	Арвайхээр	12	-	-
3	Баруунбаян-Улаан	5	-	-
4	Бат-Өлзий	27	7	25.9
5	Баян-Өндөр	18	-	-
6	Баянгол	22	-	-
7	Богд	29	-	-
8	Бүрд	9	-	-
9	Гучин-Ус	13	-	-
10	Есөнзүйл	15	-	-
11	Зүүнбаян-Улаан	8	-	-
12	Нарийнтээл	18	-	-
13	Өлзийт	11	-	-
14	Сант	9	-	-
15	Тарагт	10	-	-
16	Төгрөг	15	-	-
17	Уянга	15	-	-
18	Хайрхандулаан	24	-	-
19	Хархорин	23	11	47.8
20	Хужирт	12	-	-
Нийт дүн		429	119	27.7

Дээрх хүснэгтээс үзэхэд Аймаг болон Бат-Өлзий, Хархорин сумд 2023-2025 онд хэрэгжсэн ТАХ-ний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа захиалагчийн хяналтын зардлыг тусгасан, бусад сумд тусгаагүй байна. Үзүүлэлтийн хувьд Аймаг 74.8%, Хархорин сум 47.8%, Бат-Өлзий сум 25.9%-тай байна. Дээрх 119 ТАХ-ний гэрээнд захиалагчийн хяналтын зардлыг 92.4 хувь нь зохих хувь хэмжээгээр тусгасан байна. Үүнд:

Хүснэгт 6. Захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд зохих хувь хэмжээгээр тусгасан ТАХ тоо

№	Аймаг, сумдын нэр	ТАХ-ний тоо	Захиалагчийн хяналтын зардлыг зохих хэмжээгээр тусгаж суутгасан ТАХ-ний тоо	Хувь
1	Аймаг	101	92	91.0
2	Бат-Өлзий	7	7	100
3	Хархорин	11	11	100
Нийт дүн		119	110	92.40

Хүснэгт 7. Захиалагчийн хяналтын зардлын хэмжээг зохих хувиар тусгаагүй аймгаас хэрэгжүүлсэн ТАХ-ний гэрээний жагсаалт /мян.төг/

№	Гэрээний огноо	ТАХ-ний нэр	Гэрээний нийт үнэ	Захиалагчийн хяналтын зардал
			БУАжил	Хувь
1	2023.03.02	Арвайхээр сумын Спортын ордны нийтийн бие засах газар, дотор засварын ажил	564,414.82	9,455.37
			377,936.17	2.50
2	2023.04.20	Баян-Өндөр сумын ЕБС-н дотуур байрны засварын ажил	89,376.63	1,432.30
			75,151.77	1.91
3	2023.07.05	Хайрхандулаан сумын Соёлын төвийн ариун цэврийн өрөөний засварын ажил	20,000.00	383.72
			16,487.52	2.33
4	2023.07.17	Арвайхээр сумын Тэмүүлэл эрдэм сургуулийн спорт заалыг урлаг заал болгох засварын ажил	79,369.35	1,188.31
			69,339.97	1.71
5	2023.07.17	Арвайхээр сумын Аэрлогийн өртөөний газгенараторин байрны засварын ажил	56,749.50	803.98
			48,481.07	1.66
6	2023.07.28	Бат-Өлзий сумын ЕБС-ийн дотуур байрны их засварын ажил	70,000.00	1,360.00
			60,470.54	2.25
7	2023.07.28	Баруунбаян-Улаан сумын эмнэлгийн засварын ажил	100,000.00	1,787.42
			86,556.88	2.07
8	2023.07.31	Зүүнбаян-Улаан сумын ЕБС-н хичээлийн байрны дээврийн засварын ажил	57,301.05	843.10
			49,076.32	1.72
9	2023.08.04	Баянгол сумын ЕБС-н барилгын дээврийн засвар	99,290.02	4,010.19
			84,214.06	4.76
10	2023.10.09	БОЭТ-ийн бохир усны шугамын засварын ажил	135,800.00	2,283.38
			115,196.64	1.98
11	2024.04.25	Арвайхээр сумын 13 дугаар баг 803 дугаар байрны гадна фасадын засвар	46,547.66	649.11
			39,418.50	1.65

12	2024.04.25	Хужирт сумын 1 дүгээр цэцэрлэгийн засварын ажил	77,246.44	1,175.82
			65,488.74	1.80
13	2024.08.28	Хужирт сумын ЕБС-н дээврийн засварын ажил	189,345.15	2,845.51
			164,651.40	1.73
14	2024.09.13	Арвайхээр сумын 9 дүгээр багийн төвийн 1,2 км авто замын засвар, шинэчлэлтийн ажил	799,050.84	12,624.26
			685,169.00	1.84
15	2024.09.24	Арвайхээр сумын 153 дугаар байрны засварын ажил	90,728.82	1,137.87
			77,756.11	1.46
16	2025.06.10	Арвайхээр сумын 8 дугаар баг 466 дугаар байрны дээврийн засварын ажил	107,560.23	1,810.66
			107,663.47	1.68

Аймгаас зарлаж буй ТАХ-ийн хувьд гүйцэтгэгч худалдан авах ажиллагаанд оролцох үедээ төсөвт өртгийн нэгдсэн товчоонд захиалагчийн хяналтын зардлыг тусган ирүүлсэн боловч төсөвчний хийсэн төсөв алдаатай байх, мөн гэрээлэх шатны арифметик алдаанаас үүдэн дээрх зөрүүнүүд үүсэж байна.

Дээр дурдсан 16 ажлын гэрээнд захиалагчийн хяналтын зардлыг тусгахдаа 5 ажлын хувь хэмжээг хэтрүүлсэн, бусад 11 ажлын хувь хэмжээг дутуу тооцсон байна. Эдгээр зөрүүнүүдийг жишээгээр харуулбал. Үүнд:

Төсөвт өртгийн нэгдсэн товчоог гүйцэтгэгч боловсруулахдаа зохих хувь хэмжээгээр тооцдоггүй.	Төсөвт өртгийн нэгдсэн товчооноос гэрээнд бичихдээ арифметик алдаа гаргадаг.
---	--

ТӨСӨВТ ӨРТГИЙН НЭГДСЭН ТОВЧОО

Д/Д	Зардлын нэр	Бүгд өртөг /төгрөг/
1	Ажиллах хүчний зардал	49,410,347
2	Материал	83,737,246
3	Тээвэр	6,509,222
4	Машин ашиглалт	2,618,909
	Шууд зардлын дүн	142,275,724
5	Барилгын удирдлага, зохион байгуулалтын зардал	15,398,608
6	Ашиг	9,051,150
	Барилга угсралтын ажлын дүн	166,725,482
7	НӨАТ 10%	16,672,548
8	Нормчлолын сан 0.18%	256,096
	Дүн	183,654,127
9	Захиалагчийн албаны зардал	2,845,514
10	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	-
11	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	-
	Дүн	186,499,641
12	Магадлашгүй ажил 2%	2,845,514
13	Бусад нэмэгдэл зардал	-
	Дүн	189,345,155

БУА-ын 2 хувиар тооцохоос 1.73 хувиар буюу 0.27 хувь дутуу тооцсон.

ТӨСӨВТ ӨРТГИЙН НЭГДСЭН ТОВЧОО

Д/Д	Зардлын нэр	Бүгд өртөг /төгрөг/
1	Ажиллах хүчний зардал	21,329,679
2	Материал	46,768,521
3	Тээвэр	2,740,851
4	Машин ашиглалт	1,238,199
	Шууд зардлын дүн	72,077,250
5	Барилгын удирдлага, зохион байгуулалтын зардал /61 %/	6,847,340
6	Ашиг / 15%/	11,808,688
	Барилга угсралтын ажлын дүн	90,533,278
7	НӨАТ 10%	9,053,328
8	Нормчлолын сан 0.18%	162,960
	Дүн	99,749,566
9	Захиалагчийн техник хяналтын зардал	1,810,666
10	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	3,284,000
11	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	905,333
	Дүн	105,749,565
12	Магадлашгүй ажил 2 %	1,810,666
13	Бусад нэмэлт зардал	0
	Дүн	107,560,230

БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭГГЭХ ГЭРЭЭ

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Арвайхээр сум
Дугаар БЗ-13/2025-ӨВАХААГ/20250201011/03/01

Нэг талаас Өвөрхангай аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас "Лорд хаус" ХХК (цаашид "гүйцэтгэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Гэрээ байгуулах үндэслэл: Өвөрхангай аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн "Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай" А/396 дугаар захирамж, аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн "Гэрээ байгуулах эрх олгох тухай" 175 тоот албан мэдэгдэлийг тус тус үндэслэв.

1. Монгол Улсын Иргэний, Барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Гүйцэтгэгч тал нь Арвайхээр сумын 8 дугаар баг 466 дугаар байрны дээврийн засварын ажлыг (цаашид "ажил" гэх) аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөнөөрөг оруулалтын 107,560,230 (нэг зуун долоон сая таван зуун жаран зургаан мянга хоёр зуун гучин) төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэнэ. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.

3. Гэрээний нийт дүн: 107,560,230 төгрөг. Үүнээс:

БУАжил:	107,663,474
НӨАТ:	10,766,347
Нормчлолын сан:	162,960
Захиалагчийн хяналтын зардал:	1,810,666
Зураг төслийн ажлын дүн:	3,284,000
Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал:	905,333
Магадлашгүй ажил:	1,810,666

Захиалагч нь Худалдан авах эрх олгохдоо Худалдан авах ажиллагаанд ирүүлсэн мэргэшсэн төсөвчнөөр баталгаажсан төсөвт өртгийн нэгдсэн товчоог захиалагчийг төлөөлж гэрээ байгуулах эрх бүхий этгээдэд хүргүүлэх шаардлагатай. Энэ нь гэрээний нийт дүнг зардлын нэр төрөл бүрээр бүрэн тусгах, гүйцэтгэгчид санхүүжилтийг төсөвлөсөн зөв дүнгээр олгох, суутгах зардлуудыг бүрэн тусгах нөхцөл, боломжийг бүрдүүлж ажиллах шаардлагатай байна.

Сум - Сумдын хувьд ихэнх сумын ОНХС-с хэрэгжүүлж буй ТАХ-ний гэрээнд захиалагчийн хяналтын зардлыг тусгахгүй байна. Үүнээс үүдэлтэй гарч болох алдагдсан боломжийн зардлыг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 8. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-үүдээс захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд тусгах боломжтой байсан ажлын тоо, зардал

№	Сумдын нэр	ТАХ-ний тоо	Гэрээний нийт дүн	Захиалагчийн хяналтын зардал
1	Арвайхээр	7	634,254.08	9,513.81
2	Баруунбаян-Улаан	3	216,100.00	3,241.50
3	Бат-Өлзий	3	349,658.77	5,244.88
4	Баян-Өндөр	3	284,798.80	4,271.98
5	Баянгол	3	188,522.00	2,827.83
6	Богд	9	1,022,103.92	15,331.56
7	Бүрд	5	938,682.37	14,080.24
8	Гучин-Ус	5	1,532,525.57	22,987.88
9	Есөнзүйл	2	277,980.00	4,169.70
10	Зүүнбаян-Улаан	2	192,483.22	2,887.25
11	Нарийнтээл	6	584,663.63	8,769.95
12	Өлзийт	2	236,304.20	3,544.56
13	Сант	2	339,318.71	5,089.78
14	Тарагт	2	198,249.06	2,973.74
15	Төгрөг	3	330,885.33	4,963.28
16	Уянга	6	580,114.11	8,701.71
17	Хайрхандулаан	3	207,021.86	3,105.33
18	Хархорин	3	359,451.76	5,391.78
19	Хужирт	3	200,332.51	3,004.99
Нийт дүн		72	8,673,449.90	130,101.75

**БУА-с захиалагчийн хяналтын зардлын хувилан тооцдог тул нийт гэрээний дүнгээс дундаж хувиар тооцсон.*

Дээрх хүснэгтэд сумдад 2023-2025 онд сумын захиалгаар хийгдсэн ТАХ-үүдээс захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд тусгах боломжтой байсан ажлуудыг түүвэрлэн тооцоолол хийв. Төрийн аудитын байгууллагын өмнөх онуудад хийсэн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын судалгаа, тулгалтыг ашигласан болно.

Дээрх 19 ТАХ-ний захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд тусгаснаар 130.1 сая төгрөгийг алдагдсан боломжийн⁴ зардал гэж тооцон үзэхэд сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгждэг малчид болон иргэдэд шаардлагатай дараах ажлуудыг хийх боломж байсан. Үүнд:

- Нэг бүр нь 25.0 сая төгрөгийн өртөг бүхий 5 гүн өрмийн худаг
- Сумын иргэдэд зориулсан 130.1 сая төгрөгийн өртөг бүхий нийтийн 00, халуун усны байгууламж

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- Сумдын хувьд гүйцэтгэгч худалдан авах ажиллагаанд оролцох үедээ төсөвт өртгийн нэгдсэн товчоонд захиалагчийн хяналтын зардал тусгадаггүй, үүнийг үнэлгээний хороо шууд хүлээн авдаг зөрчил дийлэнх байна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь заалтыг аймаг, сумдад мөрдөөгүй,

⁴ Микро эдийн засгийн онолд алдагдсан боломжийн зардал (opportunity cost) гэдэг нь хязгаарлагдмал нөөцийн нөхцөлд харилцан үл нийцэх (нэгийг нь сонговол нөгөөг нь сонгож болохгүй) хэд хэдэн сонголтоос нэгийг нь хийх үед орхигдсон хамгийн сайн хувилбарын үнэ цэнийг хэлнэ гэж заасан. / нэг хувилбарыг сонгох үед бусад хувилбаруудаас авч болох байсан боломжит ашиг алдагдах/

ТАХ-ний гэрээнд захиалагчийн хяналтыг хэн, ямар хэлбэрээр хэрэгжүүлэхийг тодорхой тусгаагүй байна.

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга болон авто замтай холбоотой аймгийн зарим ажил, сумдын ихэнх ТАХ-ний гэрээнд нийт төсөвт өртгийн задаргааг дэлгэрэнгүй бүрэн оруулаагүй байна.
- Сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй томоохон ТАХ-д тавих захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй байна.
- Аймгаас зарлаж буй ТАХ-үүдийн хувьд гүйцэтгэгч худалдан авах ажиллагаанд оролцох үедээ төсөвт өртгийн нэгдсэн товчоонд захиалагчийн хяналтын зардлыг тусган ирүүлсэн боловч төсөвчний хийсэн төсвийн алдаа болон гэрээлэх шатны арифметик алдаанаас шалтгаалж зөрүү үүссэн байна.

3.2. Захиалагчийн хяналтын зардлыг гэрээний дагуу бүрэн санхүүжүүлээгүй бөгөөд хоорондын тооцоог хийж баталгаажуулаагүй байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний захиалагчийн хяналтын зардлыг аймгийн 100100051414 Өв.Техник хяналт дансанд төвлөрүүлсэн байна. Тус дансны 2023-2025 оны орлого, зарлага, татан төвлөрүүлэлтийг харуулбал:

Хүснэгт 9. Захиалагчийн хяналтын зардлын 1001000051414 дансны орлого, зарлага /2023-2025 он мян.төг/

ОРЛОГО					
Дансны дугаар	Эх үүсвэр	2023 он	2024 он	2025 он	Нийт дүн
	Дансны эхний үлдэгдэл	1,042,271.0	1,231,111.1	1,319,156.5	
-	УТХО	743,277.6	1,333,086.6	493,687.0	2,570,051.2
100100051300	ОНХО	31,284.2	-	258,198.1	289,482.3
100100052400	ОНХС	95,540.8	-	61,167.2	156,707.9
100100000350	Өв.ХО-ын барьцаа			119,122.2	119,122.2
100100051000	Өв.Засаг дарга	16,734.0		45,644.0	62,378.0
	Нийт орлого	886,836.6	1,333,086.6	977,818.4	3,197,741.6
	Дансны орлогын нийт дүн	1,929,107.6	2,564,197.7	2,296,974.9	
ЗАРЛАГА					
Харилцагч байгууллага	Зардлын нэр төрөл	2023 он	2024 он	2025 он	Нийт дүн
ГХБХБГ	Захиалагчийн хяналт	87,761.4	449,133.4	215,180.8	752,075.6
Аймгийн ЗДТГ	Захиалагчийн хяналт		68,510.7	30,367.9	98,878.6
Зохиогчийн компаниуд	Зохиогчийн хяналт	62,281.6	94,124.2	43,023.5	199,429.4
Зургийн компаниуд	Зураг төсвийн зардал	137,548.2	93,292.0	242,809.6	473,649.8
ДШЛ	Эрдэнэ музейн "Аялал жуулчлалын гудамж"-2021 төслийн үлдэгдэл санхүүжилт /2021 он/	19,837.3			19,837.3
Сод-Ээл ХХК	Хайрхандулаан сумын сургуулийн засварын үлдэгдэл санхүүжилт /2022 он/	2,278.4			2,278.4
Өв Дулаан	Баянгол сумын Уламжлалтын эмнэлгийн барилгын үлдэгдэл санхүүжилт	11,615.3			11,615.3
ХАНГАМЖ-ӨРГӨӨ ХХК	Тарагт сумын ЗДТГ-ын барилгын санхүүжилтийн үлдэгдэл /2020 он/			72,603.9	72,603.9
Тэрхийн ундраа	Баянгол сумын Соёлын төвийн барилгын үлдэгдэл санхүүжилт /2021 он/		39,980.8		39,980.8
Рагуса ХХК	Туршлага судлах, сургалтын зардал-Өв	22,350.0			22,350.0
	Нийт зарлагын дүн	343,672.2	745,041.2	603,985.8	1,692,699.2
Ерөнхий орлогын данс	Орлого төвлөрүүлэв	354,324.3	500,000.0	1,000,000.0	1,854,324.3
	Дансны эцсийн үлдэгдэл	1,231,111.1	1,319,156.5	692,989.1	

Дээрх хүснэгтээс харахад тус дансны 2023 оны эхний үлдэгдэл 1,042,271.0 мянган төгрөг, захиалагчийн хяналт хийгдэж буй ТАХ-ний төсөв болон тоо хэмжээнээс хамааран 2024-2025 онд орлого өссөн байна. Зарцуулалтын хувьд 2024, 2025 онд захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагуудад санхүүжилтийг түлхүү олгосон байна. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 2 дугаар зүйлийн 2.10.5⁵-д заасны дагуу ерөнхий орлогын данс руу 2023-2025 онд орлого болгон нийт 1,854,324.3 мянган төгрөг төвлөрүүлсэн

Нийт 1,692,699.2 мянган төгрөгийн зардлаас:

- Захиалагчийн хяналтын зардалд ГХБХБГ-т 752,075.6 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-т 98,878.6 мянган төгрөг
- Зохиогчийн хяналтын зардалд 199,429.4 мянган төгрөг,
- Зургийн төсвийн зардалд 473,649.8 мянган төгрөг,
- 2020-2022 оны 5 ТАХ-ний үлдэгдэл санхүүжилт болох 146,315.8 мянган төгрөгийг гүйцэтгэгч компанид шилжүүлсэн байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 83 дугаар тушаал батлагдсан “Барилгын захиалагчийн хяналтын талаар авах арга хэмжээний тухай” журмын 2 дугаар зүйлийн 2.1.4⁶ дэх заалтыг зөрчин аймгийн Засаг даргын 2023 оны А/576 тоот захирамжаар шууд шилжүүлэг хийн Турк улс руу туршлага судлах, сургалтад суух 3 хүний зардалд 22,350.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2.5.⁷-д заасныг зөрчин тус данснаас зураг төсвийн зардлыг шилжүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2025 онд санхүүжүүлсэн ТАХ-үүдээс гэрээнд захиалагчийн хяналтын зардлыг тусгасан ажлуудыг харуулав:

Хүснэгт 10. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023-2025 онд үндсэн гэрээнд захиалагчийн хяналтын зардлыг тусгасан ТАХ-ны мэдээлэл /мян.төг/

Эх үүсвэр	Огноо	Нийт ТАХ-ны тоо	Нийт гэрээний дүн	Үүнээс: Захиалагчийн зардал гэрээнд тусгагдсан ажлууд	
				ТАХ-ны тоо	Гэрээний дүн
ОНТХО	2023	25	1,772,444.0	17	24,104.6
	2024	39	3,096,604.3	17	42,260.5
	2025	17	2,277,040.0	13	29,294.0
	Дүн	81	7,146,088.3	47	95,659.1
ОНХС	2023	46	6,408,705.5	24	71,335.0
	2024	23	2,201,227.0	17	98,538.7
	2025	11	2,234,855.6	7	17,556.7
	Дүн	80	10,844,788.1	48	187,430.4
Авто замын сан	2023	9	1,208,539.3	2	16,734.0
	2024	8	925,133.0	3	14,294.7
	2025	5	1,020,308.6	1	13,253.1
	Дүн	22	3,153,980.9	6	44,281.8
ОНТХО, ОНХС, Автозам	2023	80	9,389,688.8	43	112,173.6
	2024	70	6,222,964.3	37	155,093.8
	2025	33	5,532,204.2	21	60,103.8
Нийт дүн		183	21,144,857.3	101	327,371.2

Дээрх хүснэгтээс харахад аймгийн хэмжээнд Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт 21,144,857.3 мянган төгрөгийн 183 ТАХ-ээс /бараа, ажил/ 327,371.2

⁵ 2.10.5.Төсвийн захирагч нь захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ хэрэгжсэний дараа захиалагчийн хяналтын үлдэгдэл санхүүжилтийг тухайн төсвийн жилд багтаан улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

⁶ “Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлыг гүйцэтгэгч байгууллагын дансанд бүрэн шилжүүлэх, хяналтын зардлыг зориулалт бусаар захиран зарцуулахгүй байх”

⁷ төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх;“

мянган төгрөгийн 101 ТАХ-нд /ажил/ захиалагчийн хяналтын гэрээ хийгдсэн бөгөөд үүнээс захиалагчийн хяналтын зардлыг суутгасан 218,367.2 мянган төгрөгийн 66 ТАХ /ажил/ байна. Нийт 22 ТАХ-ний 30,876.37 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг техник хяналтын данс руу шилжүүлээгүй хөрөнгө оруулалтын үндсэн дансанд үлдсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар хөрөнгө зарцуулах шийдвэр гаргахдаа улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-д хийгдсэн захиалагчийн хяналтын зардлаас нийтэд нь шийдвэр гарган санхүүжилтийн эрхийг аймгийн ГХБХБГ, ЗДТГ-т олгож байна. Иймд доорх хүснэгтэд нийт улсын болон орон нутгийн төсвийн захиалагчийн хяналтын нийт зардлаас олгосон санхүүжилтийг бөөн дүнгээр харуулав.

Хүснэгт 11. Захиалагчийн хяналтын нийт зардлаас олгосон санхүүжилт /мян.төг/

Огноо	ГХБХБГ			Аймгийн ЗДТГ		
	Үндсэн данс	Нэмэлт данс	Нийт санхүүжилт	Үндсэн данс	Нэмэлт данс	Нийт санхүүжилт
2023 он	-	87,761.4	87,761.4	-	-	-
2024 он	121,800.0	327,333.4	449,133.4	-	68,510.7	68,510.7
2025 он	56,000.0	159,180.8	215,180.8	-	30,367.9	30,367.9
ГХБХБГ-ын нийт санхүүжилт			752,075.6	Аймгийн ЗДТГ нийт санхүүжилт		98,878.6

Аймгийн ГХБХБГ нь 2023-2025 онд нийт 752,075.6 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардлын санхүүжилтийг үндсэн дансаар 177,800.0 мянган төгрөг, нэмэлтийн дансаар 574,275.6 мянган төгрөг тус тус авсан байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.12.1 дэх заалт “Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг өөрийн нэмэлт төсвийн дансаар дамжуулан хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- Аймгийн ЗДТГ нь 2024, 2025 онд нийт 98,878.6 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах” зардлын зориулалт болон арга хэмжээний ангиллын дагуу “82404-Барилгын техник хяналт”-д зарцуулалтын эрхээ тавиулаагүй, “80101-Үндсэн үйл ажиллагааны зардал” арга хэмжээнээс зарцуулсан байна.
- Аймгийн ГХБХБГ нь 2023-2025 онд нийт 177,800.0 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын санхүүжилтийг байгууллагын үндсэн дансаар авч Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.12.1 дэх заалт “Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг өөрийн нэмэлт төсвийн дансаар дамжуулан хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулна” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.
- Аймгийн Засаг даргын 2023 оны А/576 тоот захирамжаар Турк улс руу туршлага судлах, сургалтад суух 3 хүний зардалд 22,350.0 мянган төгрөгийг зориулалт бусаар санхүүжүүлсэн байна.
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2.5. дахь заалтыг бүрэн мөрдөөгүй 100100051414 Өв.Техник хяналт данснаас зураг төсвийн зардал -473,649.8 мянган төгрөг, санхүүжилтийн үлдэгдэл-146,315.8 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.
- Аймгийн СТСХ нь аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-тай хоорондын тооцоог бүрэн тулган баталгаажуулж, акт үйлдээгүй байна.

- Нийт 22 ТАХ-ний 30,876.37 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг техник хяналтын данс руу шилжүүлээгүй хөрөнгө оруулалтын үндсэн дансанд үлдсэн байна.

3.3. Захиалагчийн хяналтын зардлыг батлагдсан зориулалтын дагуу зарцуулсан байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 04 сарын 11-ны өдрийн 83 дугаар тушаалын хавсралтаар “Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрөл”-ийг баталсан. Үүнд:

- Барилгын захиалагчийн хяналт хийхтэй холбогдон гарах гэрээт инженер, техникийн ажилтан, барилгын материалын лабораторийн шинжээч болон лаборантын ажлын хөлс, урамшуулал, албан томилолтын зардал
- Барилга захиалагчийн хяналт хийхтэй холбогдон гарах тээврийн хэрэгсэл, шатахуун, сэлбэг хэрэгслийн зардал
- Барилга захиалагчийн хяналт хийхтэй холбогдон гарах шуудан холбоо, албан хэрэг хөтлөлт, архивын нэгж болгон хадгалахад гарах зардал
- Захиалагчийн хяналт хийхэд шаардлагатай компьютер, тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийн зардал
- Шаардлага гарсан тохиолдолд барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн тодорхой хэсэг буюу зангилаа далдлагдсан ажлаас сонгон авч задлан үзэж магадлан шалгах, мэргэжлийн шинжээч томилон судалгаа, шинжилгээ, тооцоо дүгнэлт гаргуулахтай холбогдон гарах зардал
- Барилгын материалын чанарт хяналт тавих лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хэвийн үйл ажиллагааг явуулахад гарах зардал, үл эвдэх сорилын аргаар хэмжин шалгах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах зардал
- Албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтын зардал
- Барилгын чанар, аюулгүй байдлын талаар нийтэд ил тод мэдээлэх сургалт, сурталчилгааны зардал
- Хот байгуулалтын кадастрын бүртгэл, шинээр баригдсан барилга байгууламжийн хувийн хэргийн баримт бичгийг бүрдүүлэх зардал
- Бусад зардал /хурал зөвлөгөөн, тухайн орон нутагт ашиглагдаж буй барилга байгууламжийг паспортжуулах зардал... гэх мэт холбоотой зардал/

Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.7-д “Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагдсан байх бөгөөд зардлыг зориулалтын дагуу ашиглана” гэж заасан байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний 2023-2025 онд Өв.Техник хяналтын зардлын дансанд төвлөрсөн орлогоос захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч аймгийн ЗДТГ-т нийт 98,878.6 мянган төгрөг, аймгийн ГХБХБГ-т нийт 752,075.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Зарцуулалтын арга хэмжээ бүрээр аймгийн Засаг даргын хөрөнгө зарцуулах захирамжийг гаргасан байна.

Аймгийн ГХБХБГ нь 2023-2025 онуудад дараах байдлаар захиалагчийн хяналтын зардлыг төлөвлөн зарцуулсан байна. Үүнд:

Хүснэгт 12. ГХБХБГ-н 2023-2025 оны захиалагчийн хяналтын зардлын төлөвлөлт, зарцуулалт /мян.төг/

№	Арга хэмжээний нэр	2023 он			2024 он			2025 он		
		Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү
1	Гэрээт ажиллагсдын цалин хөлс	-	-	-	63,374.4	62,900.4	474.0	83,848.5	83,848.5	-
2	Компьютер, тоног төхөөрөмж	15,841.7	15,841.7	-	22,550.0	22,550.0	-	19,900.0	19,900.0	-

3	Лабораторийн тоног төхөөрөмж, бараа материал	14,850.0	14,850.0	-	37,050.0	44,514.0	(7,464.0)	7,800.0	7,800.0	-
4	Сургалт, зөвлөгөөн	9,800.0	9,800.0	-	26,450.0	26,021.0	429.0	20,232.3	17,332.3	2,900.0
5	Томилолт	25,149.0	25,149.0	-	76,400.0	67,113.0	9,287.0	59,400.0	61,765.0	(2,365.0)
6	Шатахуун	13,819.7	13,819.7	-	31,200.0	32,823.0	(1,623.0)	24,000.0	23,035.2	964.8
7	Бичиг хэрэг	2,500.0	2,500.0	-	-	269.0	(269.0)	-	-	-
8	Автомашин худалдан авах	-	-	-	170,000.0	170,000.0	-	-	-	-
9	Автомашин сэлбэг хэрэгсэл	5,750.0	5,750.0	-	19,040.0	19,040.0	-	-	-	-
10	Бусад /техникийн нөхцөл, программын төлбөр, барилгын журнал, итгэмжлэлийн гэрээний төлбөр гэх мэт/	51.0	51.0	-	3,069.0	3,429.0	(360.0)	-	1,000.0	(1,000.0)
Нийт дүн		87,761.4	87,761.4	-	449,133.4	448,659.4	474.0	215,180.8	214,681.0	499.8

Эх сурвалж: ГХБХБГ-ын 2023-2025 оны санхүүгийн баримт, дансны хуулга

Дээрх хүснэгтээс харахад аймгийн ГХБХБГ нь 2023-2025 онуудад бүрэн зарцуулалт хийсэн бөгөөд 2024 онд 474.0 мянга, 2025 онд 499.8 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Улсын төсвийн санхүүжилтээр 2024 онд хийгдсэн ТАХ-д захиалагчийн хяналт ихээхэн хийгдсэнтэй холбоотой эх үүсвэр өсөж, 2023-2025 онд дараах зарцуулалтуудыг хийжээ. Үүнд:

- 2024 онд 170,000.0 мянган төгрөгөөр 2 автомашин худалдан авсан;
- Гэрээт ажилчдын цалин хөлсийг шийдвэрлэн-Аймгийн Засаг даргын 2024 оны А/49 дүгээр захирамжаар 2 гэрээт инженер, 1 лаборант, 1 жолооч; 2025 оны А/04 дүгээр захирамжаар 3 гэрээт инженер, 1 лаборант, 1 жолооч болгон нэмэгдүүлсэн;
- Аймгийн ГХБХБГ-ийн ерөнхий архитектор; барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн 2025.03.19-2025.03.22-ны өдрийн хооронд Тайваний Тайпей хотод ухаалаг хотуудын хөгжил, технологийн инноваци, ногоон шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр форумд оролцон, туршлага судалсан.
- 2024 онд 26,000.0 мянган төгрөгийн лабораторийн үл эвдэх сорилын хэт авиан төхөөрөмж 1 ш; 3500.0 мянган төгрөгийн бетоны агаарын агууламж тодорхойлогч багаж 1ш зэрэг тоног төхөөрөмжүүдийг худалдан авсан.
- ТАХ-ний тоо өссөнтэй холбоотойгоор албан томилолт, шатахууны зарцуулалтууд өссөн.

Харин аймгийн ЗДТГ нь 2023 онд Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжсэн ТАХ-ээс захиалагчийн хяналтын зардал аваагүй, 2024, 2025 онд дараах байдлаар зарцуулсан байна. Үүнд:

Хүснэгт 13. АЗДТГ-н захиалагчийн хяналтын зардлын зарцуулалт. 2023-2025 он /мян.төг/

№	Арга хэмжээний нэр	2023 он			2024 он			2025 он		
		Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү
1	Компьютер тоног төхөөрөмж	-	-	-	45,395.0	36,348.1	9,046.9	1,855.9	1,855.9	-
2	Автомашин сэлбэг хэрэгсэл	-	-	-	15,735.4	24,372.4	(8,637.0)	20,639.0	20,615.4	23.6
3	Техник хяналт хэрэгжүүлэх багаж хэрэгсэл	-	-	-	2,880.0		2,880.0	-	-	-
4	Шатахуун	-	-	-	4,500.3		4,500.3	-	-	-
5	Томилолт							6,000.0	6,000.0	-
6	Бусад /УБ Дулааны Сүлжээ ТӨХК-ийн инженерүүдийн дулааны шугам сүлжээний тохируулга хийх ажлын зардал/							1,873.0	1,873.0	-
Нийт дүн		-	-	-	68,510.7	60,720.5	7,790.2	30,367.9	30,344.3	23.6

Эх сурвалж: АЗДТГ-ын 2023-2025 оны санхүүгийн баримт, дансны хуулга

Дээрх хүснэгтээс харахад аймгийн ЗДТГ нь 2024 онд 68,510.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 2024 онд 36,348.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тус зардлаас худалдан авсан байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас ГХБХБГ-ын 2023–2024 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, санхүүгийн тайлан, холбогдох удирдлагын шийдвэр, ажилтнуудын цагийн бүртгэл, цалин хөлсний тооцоолол, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн суутгал, нягтлан бодох бүртгэлийн бүртгэл, орлого төвлөрүүлэлт, хөрөнгийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлт болон санхүүгийн мэдээллийн үнэн зөв, хугацаанд бэлтгэгдсэн байдалд үнэлэлт дүгнэлт өгсөн байна. Шалгалтаар төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү олгосон 615.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, газрын төлбөртэй холбоотой зөрчлийг арилгуулах 6 заалт, үйл ажиллагааг сайжруулах 2 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Аймгийн хэмжээнд 2023-2025 онуудад нийт 842,166.6 мянган төгрөгийг захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэн зориулалтын дагуу зарцуулсан байна. Зардлыг төрлөөр ангилбал:

Хүснэгт 14. Захиалагчийн хяналтын зардлын зарцуулалт. 2023-2025 он /мян.төг/

№	Арга хэмжээний нэр	Захиалагчийн хяналтын зарцуулалт	Эзлэх хувь
1	Гэрээт ажиллагсдын цалин хөлс	148,604.8	17.6%
2	Компьютер, тоног төхөөрөмж	94,639.8	11.3%
3	Лабораторийн тоног төхөөрөмж, бараа материал	67,164.0	8.0%
4	Сургалт, зөвлөгөөн	53,153.3	6.3%
5	Томилолт	160,027.0	19.0%
6	Шатахуун	69,677.8	8.3%
7	Бичиг хэрэг	2,769.0	0.3%
8	Автомашин худалдан авах	170,000.0	20.2%
9	Автомашин сэлбэг хэрэгсэл	69,777.8	8.3%
10	Бусад зардал	6,353.0	0.7%
Нийт дүн		842,166.6	100%

Нийт зардлын ихэнх буюу 20.2 хувийг автомашин худалдан авах, 19.0 хувийг томилолт, 17.6 хувийг гэрээт ажиллагсдын цалин хөлс эзэлж байгаа бол бичиг хэргийн зардал хамгийн бага 0.3 хувийг эзэлж байна.

3.4. Захиалагчийн хяналтын зардлын зарцуулалтыг ил тод мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, "Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Захиалагчийн хяналтын зардлын 2023-2025 оны зарцуулалтын талаарх мэдээллийг аймгийн ЗДТГ, ГХБХБГ нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн байршуулсан байна. Төсвийн шууд захирагчийн 2023-2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгасан бөгөөд ГХБХБГ алдаа зөрчил гараагүй бол аймгийн ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлангаар шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжийн биелэлт ирүүлэх хугацаа болоогүй байна.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх"-ээр заасан байдаг бөгөөд аймгийн ЗДТГ нь <https://uvurkhangai.gov.mn/>, ГХБХБГ нь <https://ovorkhangai.gazar.gov.mn/> гэсэн өөрийн цахим хуудсаар дамжуулан ил тод байдлын ханган ажиллаж байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2073,

Цахим шуудан: uvurkhangai@ov.gov.mn

Цахим хуудас: www.uvurkhangai.mn

2026. 04. 24 № 3/297

танай _____-ны № _____-т

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хяналтын тогтолцоо, захиалагчийн хяналтын үр нөлөө” сэдэвт аудитын тайланд өгөх саналгүй болно.

ДАРГА

Ц.ГАНБОЛД



6226 33 0292
D:My Doc. A5 alban bichig /ZDTG/



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

Өлзийтийн 1 дүгээр гудамж, 101 тоот, 8 дугаар баг,
Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62169,
Утас/факс: (976) 7032 3720,
Цахим шуудан: uvurkhangai@gazar.gov.mn,
Цахим хуудас: www.ovorkhangai.gazar.gov.mn

2026.04.23 № 210
танай 2026.04.22-ны № 347 -Т

АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хяналтын тогтолцоо, захиалагчийн хяналтын үр нөлөө” сэдэвт аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн аудитын илрүүлэлтэд харьяалагдах байгууллагын нэрийг дурдаж өгнө үү
Тусгуулах санал хүсэлт байхгүй.

ДАРГА

Т.АРИУНБОЛД



622602304

ДҮГНЭЛТ

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх ТАХ-д захиалагчийн хяналт хэрэгжүүлэхэд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам хоорондын уялдаа холбоо хангагдсан, бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.
- Аймгийн ТЕЗ болон аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймаг, суманд хэрэгжүүлсэн нийт төсөл, арга хэмжээг судлан, дүн шинжилгээ хийж холбогдох байгууллага, албан тушаалтнуудыг захиалагчийн хяналт хэрэгжүүлэх талаар бодлогын түвшинд мэдээллээр ханган, заавар, чиглэлийг өгч ажиллах шаардлагатай байна.
- Төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний тоо хэмжээнээс хамааран захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч мэргэжлийн боловсон хүчний хүртээмжтэй байдлыг харгалзан үзэж хяналтын гэрээт инженер авч ажиллуулан, шаардлагатай машин, техник тоног, төхөөрөмжөөр хангасан байна.
- Зөвлөх үйлчилгээний эрх бүхий байгууллага /иргэн, хуулийн этгээд/-р захиалагчийн хяналтыг гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн хэрэгжүүлэх талаар судлан үзэж, хэрэгжүүлэх нь зүйтэй юм.
- Захиалагчийн хяналт хэрэгжүүлдэг аймгийн ГХБХБГ болон ХБТХОХ-ийн хоорондын уялдаа хангалтгүй, дотоод хяналт сул байна. Үүнээс шалтгаалж захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд бүрэн тусгаагүй, хяналт хийгдсэн нь бүрэн нотлогдохгүй, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангасан талаарх баримт материал байхгүй байна.
- Аймгаас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС, авто замын сангаас хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлыг хууль тогтоомж, холбогдох журамд нийцүүлэн гэрээнд бүрэн тусгаагүй, сумдын түвшинд энэхүү зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн захиалагчийн хяналтын зардлыг хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд зориулалтын дагуу зарцуулсан боловч аймгийн СТСХ-ээс захиалагчийн хяналтын зардлыг гэрээний дагуу бүрэн санхүүжүүлээгүй, хоорондын тооцоог бүрэн хийж баталгаажуулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.ПҮРЭВДОРЖ ТАНАА:

- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д заасны дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн харьцуулсан судалгаа, дүн шинжилгээ хийж, захиалагчийн хяналтын талаар сумдад нэгдсэн байдлаар чиглэл, заавар өгч ажиллах.
- Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар суманд эрх шилжсэн болон сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төлөвлөлтийн шаардлага хангасан, батлагдсан зураг төсөвтэй барилга байгууламж, засвар, шугам болон бусад байгууламжийн төсөл, арга хэмжээнүүдийн захиалагчийн хяналтыг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар хийлгэх тал дээр нэгдсэн арга хэмжээ авч ажиллах. /албан даалгавар өгөх, журамлах, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах гэх мэт/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дугаар заасны дагуу захиалагчийн хяналт хэрэгжүүлэх этгээд, хэлбэрийг хэлбэрийг гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд тусгаж байх.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний гэрээг гүйцэтгэгчтэй байгуулахдаа гүйцэтгэгчээс ирүүлсэн мэргэжлийн төсөвчний хийсэн төсвийн товчооны дагуу гэрээний үнийг задалж тусгах байх. /ГХБХБГ, ХБТХОХ, сумд/
- Захиалагчийн хяналтын зардлаас санхүүжилт олгохдоо аймгийн СТСХ нь аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-тай хоорондын тооцоог бүрэн тулган баталгаажуулж, акт үйлдэж байх.

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

- Суманд хэрэгжих ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулж буй үнэлгээний хороо нь оролцогчоос ирүүлсэн, мэргэшсэн төсөвчнөөр баталгаажсан төсөвт өртгийн нэгдсэн товчоонд тусгагдсан зардлуудыг зохих хувь хэмжээгээр зөв тооцсон эсэхийг шалган, гүйцэтгэгчтэй гэрээг байгуулахдаа тухайн төсөвчний боловсруулсан төсвийн нэгдсэн товчоонд үндэслэн гэрээний үнийн задаргааг бүрэн тусгах.
- Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй төлөвлөлтийн шаардлага хангасан батлагдсан зураг төсөвтэй барилга байгууламж, засвар, шугам болон бусад байгууламжийн төсөл, арга хэмжээнүүдийн захиалагчийн хяналтыг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар /ГХБХБГ/ гүйцэтгүүлэх.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дугаар заасны дагуу захиалагчийн хяналт хэрэгжүүлэх этгээд, хэлбэрийг гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд тусгаж байх.

АЙМГИЙН ГХБХБГ-ЫН ДАРГА Т.АРИУНБОЛД ТАНАА:

- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.3.7-д заасны дагуу гүйцэтгэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар, түүний биелэлтийн талаар тухай бүрд нь тэмдэглэн, ажлын гүйцэтгэлд хавсаргаж байх. Үүнтэй холбоотой дотоод хяналтыг сайжруулах. /захиалгын хяналтын тайланд үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн бичиж, баталгаажуулж байх./

- Төсвийн тухай хуулийн 47 дугаар заалтыг мөрдөж ажиллан захиалагчийн хяналтын зардлын санхүүжилтийг өөрийн нэмэлт төсвийн дансаар дамжуулан авч байх.

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА Ц.ГАНБОЛД ТАНАА:

- Сангийн сайдын 2025 оны 112 дугаар “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах” тухай тушаалаар батлагдсан зардлын зориулалт болон арга хэмжээний ангиллын дагуу “82404-Барилгын техник хяналт” хөтөлбөр зориулалтаар захиалагчийн хяналтын зардлын санхүүжилтийг зарцуулж байх.
- Төсвийн тухай хуулийн 47 дугаар заалт, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.12.1 дэх заалтыг мөрдөн, Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах” тухай тушаалаар батлагдсан зардлын зориулалт болон арга хэмжээний ангиллын дагуу “82404-Барилгын техник хяналт” хөтөлбөр зориулалтаар, нэмэлт санхүүжилтийн дансаар нь захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагуудад захиалагчийн хяналтын зардлаас зарцуулах эрхийг олгож байх.

АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ:

- Худалдан авах ажиллагаа зохион байгуулж буй үнэлгээний хороо нь худалдан авах ажиллагаанд ирүүлсэн мэргэшсэн төсөвчнөөр баталгаажсан төсөвт өртгийн нэгдсэн товчоонд тусгасан зардлуудыг зохих хувь хэмжээг зөв тооцсон эсэхийг шалган, шалгарсан оролцогчийн ирүүлсэн төсөвт өртгийн нэгдсэн товчоог захиалагчид хүргүүлж байх.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хавсралт 1. Барилга байгууламж барих, угсралт, суурилуулалт, засвар, авто зам болон замын байгууламжийн барих, засварлах ажлуудын захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд тусгасан байдал, хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомж болон дүрэм, журам

1. Төсөл арга, хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулах. Энэ үйл явцыг захиалагч, үнэлгээний хороо гүйцэтгэх ба энэ ажил зохион байгуулах үед захиалагчийн хяналттай холбоотой	
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ	39 дүгээр зүйл. Худалдан авах гэрээ 39.1.Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ /цаашид "худалдан авах гэрээ" гэх/-ний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна. 39.2.Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно. 39.3.Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана: 39.3.5.захиалагчийн хяналт хэрэгжүүлэх этгээд, хэлбэр;
гэж заасан байгаа нь захиалагчийн хяналт хэрэгжүүлэх этгээд, хэлбэрийг Худалдан авах гэрээнд тусгах зохицуулалттай байна. Худалдан авах гэрээний загварыг үнэлгээний хороо боловсруулах бөгөөд тендерт оролцогч уг гэрээг баталгаажуулж ирүүлэх зохицуулалттай.	

2. Гүйцэтгэгч тендерийн баримт бичиг боловсруулах, төсөв боловсруулж сонгон шалгаруулалтад оролцох. Энэ үйл явцыг тендерт оролцогч гүйцэтгэх ба энэ ажилд захиалагчийн хяналттай холбоотойгоор																																		
ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ, САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ	Дөрөв. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих 4.3.8.1.захиалагчийн техник, технологийн хяналтын зардлыг холбогдох хууль, журам болон дүрэмд заасны дагуу гэрээний нийт дүнгийн 2 хувиас хэтрэхгүй байхаар тооцох, Барилгын тухай хуулийн 42.2-т заасан (өндөр, онцгой төвөгшилтэй) барилга байгууламжийн хувьд гэрээний нийт дүнгийн 5 хувиас хэтрэхгүй байхаар тооцох;																																	
БАРИЛГЫН ТӨСӨВ ЗОХИОХ ДҮРЭМ Барилгын ажлын хувьд	Дөрөв. Нэг бүрчилсэн төсвийн тооцоо Барилга угсралтын ажлын төсөвт өртөг тодорхойлох 4.53. Барилгын ажлын хувьд нэг бүрчилсэн төсвийг тооцохдоо үе шатны ажил бүрд барилга угсралтын ажлын төсөвт өртгийг тодорхойлно. Үүнд тухайн үе шатны ажлын ажилтны төсөвт цалин, үйлдвэрлэлийн инженер техникийн ажилтны цалин, нэмэгдэл цалин хөлс, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын байгууллага хариуцан төлөх шимтгэл, барилгын ажилтны хөдөлмөр хамгааллын хувцас, хөдөлмөрийн багаж хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд зарцуулах хөрөнгийн хэмжээг тооцож нэгтгээд ажиллах хүчний зардлыг гаргана. Ажиллах хүчний зардал материал, машин механизм, тээврийн зардал, барилгын удирдлага, зохион байгуулалтын зардал, төсөвт ашгийн хэмжээг тодорхойлж нэгтгэн үе шатны ажлын төсөвт өртгийг тодорхойлно. Үе шатны ажлын төсөвт өртгийг нэгтгэн барилга угсралтын ажлын төсөвт өртгийн товчоог хийнэ. Зургаа. Захиалагчийн техникийн хяналт, зохиогчийн хяналт, зөвлөхийн үйлчилгээг хэрэгжүүлэх зардлыг тодорхойлох 6.1.Захиалагчийн техникийн хяналтын зардлыг нэгдсэн төсвийн тооцооны 2-7 дугаар бүлэг (Бүлэг 2-7. Үндсэн ба туслах барилга, талбайн тохижилт, зүлэгжүүлэлт) -ийн дүнгээс 2 хувиар тооцно. Нэгдсэн төсөв зохиогдоогүй нөхцөлд барилга угсралтын ажлын төсөвт өртгийн 2 хувиар тооцно.																																	
“АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГА, ЗАСВАРЫН АЖЛЫН ТӨСӨВ БОДОХ НОРМ” ЗЗБНБД 81-013-2019 -д Авто зам, замын байгууламжийн хувьд	5.4.4.Авто замын барилга, их засварын ажлын техник, технологийн хяналтын (зөвлөх үйлчилгээ) зардлыг төсвийн шууд зардлын дүнгээс дараах хувь хэмжээгээр тооцно: <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Замын урт /км-ээр/</th> <th>Техник, технологийн хяналтын (Зөвлөх үйлчилгээ)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>0-50</td> <td>5.0</td> </tr> <tr> <td>2</td> <td>51-100</td> <td>4.8</td> </tr> <tr> <td>3</td> <td>101-150</td> <td>4.6</td> </tr> <tr> <td>4</td> <td>151-200</td> <td>4.4</td> </tr> <tr> <td>5</td> <td>201-300</td> <td>4.2</td> </tr> <tr> <td>6</td> <td>301-ээс дээш</td> <td>4.0</td> </tr> </tbody> </table> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Гүүрийн урт /м-ээр/</th> <th>Техник, технологийн хяналтын (Зөвлөх үйлчилгээ)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>200 метр хүртэл</td> <td>5.0</td> </tr> <tr> <td>2</td> <td>201-300 метр хүртэл</td> <td>4.8</td> </tr> <tr> <td>3</td> <td>301 м-ээс дээш</td> <td>4.6</td> </tr> </tbody> </table> <p>Авто замын барилга, их засварын ажлын техник, технологийн хяналтын зардал тооцох хувь</p>	№	Замын урт /км-ээр/	Техник, технологийн хяналтын (Зөвлөх үйлчилгээ)	1	0-50	5.0	2	51-100	4.8	3	101-150	4.6	4	151-200	4.4	5	201-300	4.2	6	301-ээс дээш	4.0	№	Гүүрийн урт /м-ээр/	Техник, технологийн хяналтын (Зөвлөх үйлчилгээ)	1	200 метр хүртэл	5.0	2	201-300 метр хүртэл	4.8	3	301 м-ээс дээш	4.6
№	Замын урт /км-ээр/	Техник, технологийн хяналтын (Зөвлөх үйлчилгээ)																																
1	0-50	5.0																																
2	51-100	4.8																																
3	101-150	4.6																																
4	151-200	4.4																																
5	201-300	4.2																																
6	301-ээс дээш	4.0																																
№	Гүүрийн урт /м-ээр/	Техник, технологийн хяналтын (Зөвлөх үйлчилгээ)																																
1	200 метр хүртэл	5.0																																
2	201-300 метр хүртэл	4.8																																
3	301 м-ээс дээш	4.6																																

	<p>Авто замын барилга, их засварын ажлын техник, технологийн хяналтын (зөвлөх үйлчилгээ) зардлыг төсөвт тооцсон тохиолдолд захиалагчийн хяналтын зардлыг техник, технологийн хяналтын (зөвлөх үйлчилгээ) зардлын дүнгээс 10 хувиар тооцож төсөвт тусгана.</p> <p>5.4.5. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал болон гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засвар, ээлжит засварын ажилд захиалагчийн хяналтын зардлыг төсвийн шууд зардлын дүнгээс 4 хувиар тооцно.</p> <p>5.4.6. Техник, технологийн хяналтыг захиалагч байгууллага нь хэрэгжүүлэх 5.0 тэрбум төгрөг хүртэлх төсөвт өртөг бүхий авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд захиалагчийн хяналтын зардлыг төсвийн шууд зардлын дүнгээс 2 хувиар тооцох бөгөөд техник, технологийн хяналтын зардлыг давхардуулан тооцохгүй.</p> <p>гэж тус тус заасан байна.</p>
<p>Үүнээс үзвэл 5.0 тэрбум хүртэлх төсөвт өртөг бүхий авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд зөвхөн захиалагчийн хяналтын зардал, үүнээс дээш үнийн дүнтэй бол техник, технологийн (зөвлөх үйлчилгээ) болон захиалагчийн хяналтын гэсэн зардлууд төсөвт өртөгт тусгахаар байна. Харин олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал болон гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засвар, ээлжит засварын ажилд зөвхөн захиалагчийн хяналтын зардал төсөвт тусгахаар заасан байна.</p>	

<p>3. Гүйцэтгэгчийг шалгаруулж ажил гүйцэтгэх гэрээ байгуулах. Энэ үе шатны ажил захиалагчийн хяналттай холбоотой</p>	
<p>ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ, САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ</p>	<p>Дөрөв. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих</p> <p>4.7.Гэрээний удирдлага</p> <p>4.7.3.Төсөл, арга хэмжээний гэрээнд тухайн төслийн зураг төслийн магадлалаар баталгаажсан төсөвт өртгийн задаргааны дагуу гэрээний нийт дүнг зардлын нэр төрөл бүр тусгах бөгөөд энэ нь төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртгөөс хэтрэхгүй байна. Төсөл, арга хэмжээний гэрээнд барилга угсралтын дүн, зохиогчийн хяналт, захиалагчийн техник, технологийн хяналт, магадалшгүй ажил, нэмэгдсэн өртгийн албан татвар, зураг төсөл, хайгуулын ажил, барилга байгууламжийн норм, нормативын зардлын шимтгэл гэх мэт зардлыг нэг бүрчлэн тусгахаас гадна тухайн гүйцэтгэгч татварын өртэй тохиолдолд санхүүжилтээс суутган тооцох тухай заалтыг тусгасан байна;</p>
<p>гэж заасан нь захиалагч болон гүйцэтгэгч гэрээ байгуулахдаа гэрээнд дээрх зардлуудыг тусгах ёстой. Түүнчлэн захиалагч гүйцэтгэгчид олгох санхүүжилтийн дүн ойлгомжтой болох буюу “барилга угсралтын ажил + НӨАТ” -ийн зардлыг гүйцэтгэгчид гүйцэтгэлийн дагуу шилжүүлэх нь тодорхой болгож гэрээ байгуулахаар байна.</p>	
<div style="text-align: center;"> <p>Барилга угсралтын ажлын зардал + Нэмэгдсэн өртгийн албан татвар = Гүйцэтгэгчид олгох нийт зардал</p> </div>	

<p>4. Захиалагчийн хяналт хийх гэрээ байгуулах. Энэ үе шатны ажилд захиалагч нь өөрийн хэрэгжүүлэх чиг үүргээс захиалагчийн хяналт хийх ажлыг холбогдох хуулийн этгээдэд шилжүүлнэ. Захиалагчийн хяналттай холбоотойгоор</p>	
<p>ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ, САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ</p>	<p>Дөрөв. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих</p> <p>4.4.Захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг:</p> <p>4.4.1.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу техник, технологийн захиалагчийн хяналт хэрэгжүүлэх зөвшөөрлийг авсан байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>4.4.1.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн шилжүүлсэн эрхийн дагуу захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг төсөл, арга хэмжээ тус бүрээр захиалагчтай байгуулах;</p> <p>4.4.1.6.захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэхдээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.5-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий шийдвэр гаргахгүй байх. (магадлалаар орж төсөв нэмэх асуудал)</p> <p>4.4.2.Төсөл, арга хэмжээг хуулиар баталсан хугацаанд бүрэн ашиглалтад оруулахад захиалагчийн техник, технологийн хяналтын чиг үүргийг гэрээний дагуу үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэх.</p>

<p>БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬ Барилга байгууламжийн хувьд</p>	<p>37 дугаар зүйл. Захиалагчийн чиг үүрэг 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.4.барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах; /33.1.20.барилгын үйл ажиллагаанд мөрдөх гэрээний загвар батлах;/ 37.2.Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.</p>
<p>АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬ Авто зам, замын байгууламжийн хувьд</p>	<p>21 дүгээр зүйл. Авто замын барилгын ажлын техник, технологийн хяналт 21.1.Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ. 21.3.Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний болон захиалагчийн хяналтын зардлыг тухайн авто зам, замын байгууламжийн төсөвт өртөлт тусгана.</p>

<p>5. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх. Энэ үе шатны ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй этгээд нь хяналтыг зураг, төсөв, ажлын даалгавар дээрх ажлууд, гэрээний заалтуудыг зохих хууль, тогтоомжийн дагуу хийгдэж байгаа эсэхийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн хийнэ.</p>	
<p>ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ, САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ Барилгын ажлын хувьд</p>	<p>5.3.Хяналт: 5.3.1.Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ; 5.3.2.Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.4-т заасан нөхцөл байдал илэрсэн бол холбогдох мэдээллийг эрх бүхий улсын байцаагчид хүргүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр авч ажиллана; 5.3.3.Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрд зохиогчоор хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна;</p>
<p>БАРИЛГЫН АЖЛЫН ЗАХИАЛАГЧИЙН ДҮРЭМ</p>	<p>Гурав.Захиалагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа 3.9.Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна 3.11.Захиалагч барилга байгууламжийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хийх үзлэг, шалгалтын ажилд оролцож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй.</p>
<p>АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬ</p>	<p>20 дугаар зүйл. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил 20.4.Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг магадлалын дүгнэлт бүхий баталгаажсан зураг төсөлгүй, техник, технологийн хяналтгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.</p>

<p>6. Төсөл, арга хэмжээг хүлээн авах. Энэ үе шатны ажилд гүйцэтгэгч төсөл, арга хэмжээг бүрэн дуусгаж захиалагчид хүлээлгэн өгнө. Барилга хүлээж авах үед зураг, ажлын тоо хэмжээнээс зөрүүтэй асуудал үүсэн бол ажлын явцад захиалагч зохиогчтой тохиролцож өөрчлөлт оруулсан эсэх, хэрэв өөрчлөлт ороогүй бол тухайн асуудал нь захиалагчийн хяналтаар илэрсэн эсэхийг нягтална.</p>	
<p>БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ДҮРЭМ</p>	<p>Тав. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын чиг үүрэг 5.1.6. барилгын ажлын явцад барилгын улсын техникийн хяналт хэрэгжүүлэх байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдлыг дүгнэх;</p>
<p>АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ, АШИГЛАЛТАД АВАХ ЖУРАМ</p>	<p>5.7.Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар шинэчлэлтийн ажлыг дутуу буюу хууль тогтоомж, стандарт, норм, норматив, дүрэм, зураг төсөл, техникийн нөхцөл шаардлагыг зөрчиж чанаргүй хийсэн, барилгын ажлын явцад Захиалагч болон Зөвлөх, мэргэжлийн хяналтын байгууллагуудаас тавьсан шаардлага, дүгнэлтийг биелүүлээгүй тохиолдолд ашиглалтад авахаас татгалзана.</p>
<p>гэж заасан байгаа нь ажил хүлээн авах үед захиалагчийн хяналт хийгдэж байсан, одоо үүсээд байгаа нөхцөл байдалд хэрхэн хариу арга хэмжээ авч ажилласныг үзэх зохицуулалттай байна.</p>	

Хавсралт 2. Сумдын 2023-2025 оны ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга, авто замын байгууламж, засварын төсөл, арга хэмжээнээс захиалагчийн хяналтын зардал суутгасан төсөөлөл. /мян.төг/

Он	Батлагдсан тогтоолоор	Дүн	ЗХ төсөөлөл
Арвайхээр			
2023	Гэр хорооллын ус түгээх байруудыг ухаалаг системд шилжүүлэх	54,270.1	814.1
2023	Хог ангилан ялгах, дарж булах ажлыг эрчимжүүлэх, хогийн савны тоог нэмэгдүүлэх	99,000.0	1,485.0
2023	6,9 дүгээр багт хүүхдийн тоглоомын талбайг биеийн тамирын зориулалтын тоног төхөөрөмжийн хамт байгуулах	93,040.2	1,395.6
2023	Гэр хороолол, нийтийн эзэмшлийн талбайн камерын тоог нэмэгдүүлэх	98,964.7	1,484.5
2024	Гэр хорооллын газрын хотгор, гүдгэр рельефийг тэгшлэх	117,000.0	1,755.0
2024	Өндөр гэгээн Занабазарын музейг засварлах	75,000.0	1,125.0
2025	Онцгой арын уулзварт гэрлэн дохио хийх	96,979.1	1,454.7
Баруунбаян-Улаан			
2023	Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах	85,100.0	1,276.5
2023	Гүн өрмийн худаг гаргах	61,000.0	915.0
2024	Худаг гаргах, засвар үйлчилгээ	70,000.0	1,050.0
Бат-Өлзий			
2023	Сумын төвд цамхагт гэрэлтүүлэгтэй болох	78,882.0	1,183.2
2024	Жогом хороолол руу тог татах	81,929.8	1,228.9
2024	Наадмын талбайн засвар, 2 давхар болгох, наадмын талбай руу тог татах	188,847.0	2,832.7
Баянгол			
2023	Сумын төвийн ундны усны гүний худаг шинээр гаргаж цахимжуулах, усалгааны систем холболт хийх, автоматжуулах.	48,536.4	728.0
2024	Наадмын талбайн тохижилт, морь барианы газрыг тохижуулах	89,985.6	1,349.8
2024	Гүн өрмийн худаг гаргах, Хаяа, Өндөр-Өнц багт	50,000.0	750.0
Баян-Өндөр			
2023	Хуучин халуун усны барилгыг буулгаж, шинээр халуун ус, фитнесийн төв байгуулах	150,900.0	2,263.5
2023	Сумын тохижилт ногоон байгууламж нэмэгдүүлэх, явган хүний зам тавих, нийтийн эзэмшлийн гудамж талбайн засварын үйлчилгээ	49,900.0	748.5
2024	Сумын төвийн төв талбай тохижилт	83,998.8	1,260.0
Богд			
2023	Сумын төвийн доторх нийтийн эзэмшлийн талбайн элс зөөх, гэрэлтүүлэх нэмэх	92,475.4	1,387.1
2023	Бага сургуулийг зөөж хүүхдийн хөл бөмбөгийн талбай байгуулах	189,327.7	2,839.9
2023	Эмнэлгийн морг засварлах	54,500.7	817.5
2023	сумын төвийн магистраль шугамын өргөтгөл	128,064.7	1,921.0
2024	Цахилгаан шугамын өргөтгөл	52,926.0	793.9
2024	Нийтийн халуун ус барих	190,871.0	2,863.1
2024	Ус сувгийн их засвар	120,700.1	1,810.5
2024	Морины их шүтээний засвар, талбайн тохижилт	126,500.0	1,897.5
2024	Бага сургуулийг зөөж хөл бөмбөгийн талбай байгуулах ажил гүйцэтгэх	66,738.3	1,001.1
Бүрд			
2023	Сумын төвийн хогийн цэгийг хашаажуулах	87,632.0	1,314.5
2023	2-р багт иргэний танхим байгуулах	86,500.0	1,297.5
2023	Гүний худаг гаргах, засварлах	75,000.0	1,125.0
2024	Сумын төвд 300 метр хатуу хучилттай авто зам шинээр тавих	614,550.4	9,218.3
2024	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах худаг-3ш	75,000.0	1,125.0
Гучин-Ус			
2023	Гүний худагтай болох, худаг сэргээн засах	64,972.4	974.6
2024	Төрийн албан хаагчдын орон сууцны засвар	46,978.7	704.7
2025	Төрийн албан хаагчдын орон сууц шинээр барих	1,247,974.5	18,719.6
2025	ЕБС-ийн гадна биеийн тамирын талбайг засварлах	79,800.0	1,197.0
2025	Худаг ус гаргах-3ш	92,800.0	1,392.0
Есөнзүйл			
2023	Иргэдэд тав тухтай орчин бүрдүүлэх /ТАХ-ны барилга/	207,980.0	3,119.7
2023	Багийн төвд худаг барих	70,000.0	1,050.0
Зүүнбаян-Улаан			
2024	Төрийн албан хаагчдын орон сууц	142,714.7	2,140.7

2024	22 айлын орон сууцны засвар	49,768.5	746.5
Нарийнтээл			
2023	Сумын 2 болон 4 багийн орчны гэрэлтүүлэг хийх	50,000.0	750.0
2024	Ахмадын өрөөний засвар	72,653.7	1,089.8
2024	Баянтээг багийн СӨББ-ийн барилгыг засварлах, өргөтгөх	84,148.4	1,262.2
2024	Төрийн албан хаагчдын орон сууц	188,303.8	2,824.6
2024	Баянтээг багийн Хүн эмнэлэгт ариутгал халдваргүйжүүлэлтийн өргөтгөл барих	89,899.9	1,348.5
2025	Сумын төв болон Баянтээг багийн камеруудыг засварлах, өргөтгөх	99,657.9	1,494.9
Өлзийт			
2023	Багийн төвтэй болох	62,518.2	937.8
2025	25км хатуу хучилттай замын зураг төсөв хийлгэх	173,786.0	2,606.8
Сант			
2023	сургуулийн хүүхдийн биен тамирын гадна талбайг засварлах	47,598.6	714.0
2024	Гэр хороололруу дулааны шугам оруулах	291,720.1	4,375.8
Тарагт			
2023	хогийн цэгийг хашаажуулах	49,349.1	740.2
2024	Наадмын талбай барих зураг төсөл	148,900.0	2,233.5
Төгрөг			
2024	Мазарын далангийн засвар	120,000.0	1,800.0
2024	Спортын талбай тохижуулах	126,994.5	1,904.9
2024	Сумын төвийн камер гэрэлтүүлэг	83,890.9	1,258.4
Уянга			
2023	Сумын төвийн цамхагт гэрэлтүүлэг	46,368.7	695.5
2024	Нийтийн ариун цэврийн газар байгуулах	79,572.4	1,193.6
2025	Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт /шинээр хийх тоглоомын талбай, спорт талбайн хэсгийн явган зам, талбай хийх/	169,872.7	2,548.1
2025	Сумын төвийн камержуулалтын	115,950.2	1,739.3
2025	Цэцэрлэгт хүрээлэнгийн цахилгааны дэд станц барих	48,907.4	733.6
2025	Цэцэрлэгт хүрээлэнгийн шинээр хийх гол гудамж явган зам, талбай хийх	119,442.7	1,791.6
Хайрхандулаан			
2023	ЕБС-ын стандартад нийцсэн хүнсний агуулахтай болох засварын ажил	53,502.1	802.5
2023	Зарим гудамж хороололд дулааны болон цэвэр бохирын шугамыг нэмэгдүүлэх	82,519.8	1,237.8
2023	Нийтийн амралт, хүндэтгэлийн талбайтай болох	71,000.0	1,065.0
Хархорин			
2023	Гүний худаг шинээр гаргах	89,578.3	1,343.7
2023	Сумын камержуулалт	124,973.5	1,874.6
2024	Хог хаягдал ландфилын аргаар булшлах /1,2,3-р баг/	144,900.0	2,173.5
Хужирт			
2024	1-р багийн төв барих	100,345.6	1,505.2
2024	Наадмын талбайн тохижилт	49,997.9	750.0
2024	Гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засварлах	49,989.0	749.8
		8,673,449.9	130,101.7

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/13

Арвайхээр сум

Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсэг, 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалт, 2025 оны А/161 дүгээр тушаалаар баталсан “Аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хяналтын тогтолцоо, захиалагчийн хяналтын үр нөлөө” нийцлийн аудитын тайлан, албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Нийцлийн аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, сумдын Засаг дарга, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Ө.Ринчинмядаг)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллан, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (О.Пүрэвдорж), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Т.Ариунболд), сумдын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын менежер (П.Хорлоосүрэн), ахлах аудитор (Ө.Ринчинмядаг) нарт даалгасугай.

5. “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хяналтын тогтолцоо, захиалагчийн хяналтын үр нөлөө”-нд хийсэн нийцлийн аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор статистик мэдээний бүртгэлийн маягтаар гаргаж, 5 хоногийн дотор Үндэсний аудитын газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Нийцлийн аудитын ахлах аудитор (Ө.Ринчинмядаг), Аудитор, эрх зүйч (Б.Нямсэмжаан)-д тус тус үүрэг болгосугай.

6. Аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах үйл ажиллагааг ахлах аудитор (Ө.Ринчинмядаг)-т хариуцуулсугай.

7. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 30 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Д.Очирбат)-д үүрэг болгосугай.

О.БАТЖАРГАЛ

6307010028

D:\Audiitiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 113 дугаар тушаалын хавсралт

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Зөрчлийн товч утга	Хариуцах байгууллагын нэр	Мөнгөн дүн /сая.төг/
1	Захиалагч тал болох аймгийн Засаг дарга нь Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай захиалагчийн хяналт хийх гэрээг төсөл, арга хэмжээ /2024 онд-19, 2025 онд-20/ бүрээр байгуулаагүй нэгдсэн нэг гэрээ байгуулж, захиалагчийн хяналт хийх ажлыг гэрээний хавсралтаар баталсан байна.	Аймгийн Засаг дарга	-
2	1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2025 онд хийсэн 22 ТАХ-ний 30,876.37 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг техник хяналтын Өв.Техник хяналт 100100051414 тоот дансанд төвлөрүүлээгүй байна. 2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-ний санхүүжилтийн үлдэгдэл 146,315.8 мянган төгрөг, зураг төсвийн зардал 473,649.8 мянган төгрөгийг 100100051414 Өв.Техник хяналт данснаас тус тус шилжүүлсэн байна.	Аймгийн Засаг дарга	650,841.97
3	Аймгийн Засаг даргын 2023 оны А/576 тоот захирамжаар Турк улс руу туршлага судлах, сургалтад суух 3 хүний зардалд 22,350.0 мянган төгрөгийг зориулалт бусаар санхүүжүүлсэн байна.	Аймгийн Засаг дарга	22,350.0
4	Судалгаагаар аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2023-2025 онд нийт 76 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хийсэн гэх боловч аудитаар 33 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтын тайлан ирүүлсэн тул захиалагчийн хяналт бүрэн хийгдсэн эсэх нь нотлогдохгүй байна.	Аймгийн ГХБХБГ	-
5	Судалгаагаар аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс нь 2023-2025 онд нийт 25 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хийсэн гэх боловч аудитаар 9 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтын тайлан ирүүлсэн тул захиалагчийн хяналт бүрэн хийгдсэн эсэх нь нотлогдохгүй байна.	Аймгийн ЗДТГ	-
Нийт дүн			673,191.97

D:\Audiitiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

Утас: +976 7032-3253, 70323-833, 7032-3108

Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Монгол улс, Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон